

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үг, хүснэгтэн мэдээллийн жагсаалт	2
ҮАГ-ын Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор	Аудит хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
Б.Алтанзул	Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт	4
Ахлах аудитор	Үндсэн мэдээлэл	5-6
Я.Наранцэцэг	1. Төлөвлөлтийн үе шатны бэлтгэл ажил бүрэн хангагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх;	7-8
Нийслэл дэх Төрийн аудитын газрын Аудитор	2. Сонгон шалгаруулалтыг холбогдох хууль журмын дагуу явуулсан эсэх;	9-10
Ж.Энхтуяа	3. Ажил гүйцэтгэх гэрээг холбогдох хууль, журамд нийцүүлэн байгуулж, магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсвөөр ажлыг гүйцэтгэсэн эсэх;	11-13
Шинжээч	4. Төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлд захиалагчийн болон зохиогчийн хяналт тавьж, санхүүжилтийг хууль, журмын дагуу олгосон эсэх;	14-16
Б.Гоцбаяр	5. Төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг холбогдох эрх зүйн актын дагуу ашиглалтад хүлээн авч, данс бүртгэлд тусгасан эсэх.	16
Б.Ананд		
2017 оны 5 дугаар сар		
Уг тайланг ҮАГ-ын Вэб сайтаас үзнэ үү. www.audit.mn	Дүгнэлт	17
Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261729, 260949 дугаарын утас, факсаар харилцана уу.	Зөвлөмж	18-19
	Шалгагдагч байгууллагын санал	20-24
	Үндэсний Аудитын газрын тайлбар	25-26
	Хавсралтууд	27-35
Хаяг: Монгол Улс Улаанбаатар хот 15160 Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3 Засгийн газрын IY байр Үндэсний аудитын газар	Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал	36

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдах авах тухай хууль
Засгийн газар	ЗГ
ҮАГ	Үндэсний аудитын газар
БХБ	Барилга хот байгуулалт
ЗТБХБ	Зам тээвэр, барилга, хот байгуулалт
ЗТХ	Зам тээврийн хөгжил
ЗТ	Зам тээвэр
ЭЗХ	Эдийн засгийн хөгжил
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НАЗХГ	Нийслэлийн Авто замын хөгжлийн газар
НЕТГ	Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НМХГ	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар
НӨХГ	Нийслэлийн Өмчийн харилцааны газар
ТУХ	Төслийн удирдах хороо

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1	“Гудамж” төслийн нийт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний жагсаалт, санхүүжилт
Хүснэгт 2	“Гудамж” төслийн Нийслэлд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс аудитын түүвэрт хамрагдсан төсөл, арга хэмжээний жагсаалт
Хүснэгт 3	Мэргэжлийн шинжээчдээр дүгнэлт гаргуулахаар түүвэрлэсэн төсөл, арга хэмжээний жагсаалт
Хүснэгт 4	2014 онд “Гудамж” төслийн хүрээнд нийслэлд хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөгөө
Хүснэгт 5	2015, 2016 оны Төсвийн тухай хуулиар Хөгжлийн банкны эх үүсвэрээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүн
Хүснэгт 6	Нэмэлт гэрээний үнийн дүн анхны гэрээний үнийн дүнгийн зөрүүг харуулсан судалгаа
Хүснэгт 7	2013-2016 онд нийслэлд хэрэгжүүлсэн уулзвар, авто зам, зураг төсвийн ажилд олгосон санхүүжилт

Аудит хийх үндэслэл:

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын 2017 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 01/145 дугаар албан бичгийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд энэхүү аудитыг хийлээ.

1. Аудитын нэр:

“Гудамж” төслийн нийслэлд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хөрөнгийн зарцуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилт

2. Аудитын код:

ҮАГ-НАГ/2017/10-ЭА

3. Аудитын зорилт:

“Гудамж” төслийн хүрээнд хэрэгжсэн ажлын төсөвт өртгийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган санал, зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт оршино. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Төлөвлөлтийн үе шатны бэлтгэл ажил бүрэн хангагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх;
- Сонгон шалгаруулалтыг холбогдох хууль журмын дагуу явуулсан эсэх;
- Ажил гүйцэтгэх гэрээг холбогдох хууль, журамд нийцүүлэн байгуулж, магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсвөөр ажлыг гүйцэтгэсэн эсэх;
- Төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлд захиалагчийн болон зохиогчийн хяналт тавьж, санхүүжилтийг хууль, журмын дагуу олгосон эсэх;
- Төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг холбогдох эрх зүйн актын дагуу ашиглалтад хүлээн авч, данс бүртгэлд тусгасан эсэх.

4. Хамрах хүрээ:

“Гудамж” төслийн нийслэлд хэрэгжүүлсэн нийт 33 уулзвар, авто замын ажлаас 20 уулзвар авто замын ажлыг аудитад хамруулж, Сангийн яамны харьяа “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийн нэгжээс “Гудамж” төслийн хэрэгжүүлсэн уулзвар, авто замын ажлын холбогдох баримтуудыг, Хөгжлийн банкнаас харилцах дансны мэдээллүүдийг, Нийслэлийн Өмчийн харилцааны газраас хөрөнгийн бүртгэлтэй холбоотой гаргасан шийдвэрүүдийг авч, Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын лабораторийн шинжилгээг хамруулан төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, сонгон шалгаруулалт, гүйцэтгэл, захиалагчийн хяналтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэхийг авч үзсэн.

Одоогийн байдлаар “Гудамж” төслийн нэгжийн 2013-2016 онуудад хэрэгжүүлсэн ажлууд Авилгатай тэмцэх газарт шалгагдаж байгаа бөгөөд аудитад хамрагдсан 20 төсөл, арга хэмжээний баримт материалуудыг авч үзэхэд холбогдох баримтуудыг бүрэн бус ирүүлсний улмаас Авилгатай тэмцэх газраас 5, “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төсөл”-өөс 4 удаа нэмж материал татаж авч үзсэн. 9 удаа баримт материал авч үзэхэд цаг хугацаа ихээхэн зарцуулж, аудитын үйл ажиллагаанд хүндрэл учирч байсан.

5. Арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 300, АДБОУС 400, АДБОУС 4000, АДБОУС 4100, Төрийн хяналт шалгалтын стандартуудыг баримталж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга, лавлагаа, тайлбар, мэдээ гаргуулах, нотлох баримтыг баталгаажуулах, санхүүгийн болон хяналтын тайланг судлах зэрэг аудитын хөтөлбөр, горим, арга зүйн дагуу цуглуулсан нотлох зүйл, баримт материалд дүн шинжилгээ хийж, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрлэн шалгаж баталгаажуулав.

6. Аудит хийхэд ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглалаа. Үүнд:

- 2008 онд батлагдсан Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 13 дугаар зүйлийн 13.2, 13.5, 16 дугаар зүйлийн 16.2, 17 зүйлийн 17.1.3;
- 2016 онд батлагдсан Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3;
- Монгол улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1;
- ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.6;
- Монгол улсын Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4;
- ЗГ-ын 2013 оны 46, 71, 81, 2016 оны 196 дугаар тогтоол;
- ЭЗХ-ийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар баталсан “ЗГ-ын үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх, төслийг хэрэгжүүлэхэд баримтлах түр журам”;
- ЗГ-ын 2010 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Барилгын зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх, барилгын үе шатны ажилд хяналт тавих, ашиглалтад оруулах хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэх дүрэм”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3, 10 дугаар зүйлийн 10.1;
- ЗГ-ын 2012 оны 151 дүгээр тогтоолоор баталсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2.1, 4 дүгээр зүйлийн 4.13.9, 4.12.1, 4.12.7;
- Дэд бүтцийн сайдын 1999 оны 196 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийх дүрэм”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3, 1.9;
- ЗГ-ын 2009 оны 72 дугаар тогтоолоор баталсан “Барилгын захиалагчийн дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.1.7;
- Хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан ЗГ-ын үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам;
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.

7. Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн болон хугацаа:

Аудитыг ҮАГ-ын Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Б.Алтанзул хянан удирдаж, Нийцлийн аудитын газрын аудитор М.Туул, Нийслэл дэх Төрийн аудитын газрын аудитор Ж.Энхтуяа, шинжээч Б.Ананд нар 2017 оны 4 дүгээр сарын 3-ны өдрөөс 2017 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл төлөвлөлтийг хийж, аудитын бүрэлдэхүүнд 2017 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр шинжээч Б.Гоцбаярыг татан оролцуулж, 2017 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс 2017 оны 5 дугаар сарын 5-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатыг хийж гүйцэтгэлээ.

8. Үндсэн мэдээлэл:

ЗГ-ын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор ЗГ-ын 2013 оны 46, 71 дүгээр тогтоолуудаар “Гудамж” төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулсан. Улмаар ЗГ-ын 2013 оны 81 дүгээр тогтоолоор “Гудамж” төслийн эхний ээлжийн санхүүжилт болох 200.0 сая ам.доллар буюу 279 710.0¹ сая төгрөгийг ЗГ-ын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.

ЭЗХ-ийн сайдын 2013 оны “Хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан ЗГ-ын үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх, төслийг хэрэгжүүлэхэд баримтлах түр журам”-аар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулж байв.

2013-2016 онуудад төслийн нэгжийн хэрэгжүүлсэн нийт 145 514.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй 107 төсөл, арга хэмжээний 79.9% /гэрээний үнийн дүнгийн/ нь нийслэлд хэрэгжсэн бөгөөд Хөгжлийн банкнаас 116 263.5 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий уулзвар, авто зам, зураг төсвийн 99 ажилд 95 732.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Үүнийг хүснэгт №1-ээр харуулбал:

Д / Д	Төсөл, арга хэмжээний төрөл	Нийт			Үүнээс:		
		ажлын тоо	гэрээний дүн /сая.төг/	олгосон санхүүжилт /сая.төг/	нийслэлд хэрэгжүүлсэн ажлын тоо	гэрээний дүн /сая.төг/	олгосон санхүүжилт /сая.төг/
1	Уулзвар	22	41 648.4	30 504.5	22	41 648.4	30 504.5
2	Авто зам	5	47,907.4	40,601.3	5	47,907.4	40,601.3
3	Хүй 7 худаг орчмын авто зам, зогсоол	3	13,868.8	13,290.4	3	13,868.8	13,290.4
4	Гандантэгчилэн хийд орчмын гудамжны зам, барилга	3	1,510.7	1,145.5	3	1,510.7	1,145.5
5	Архангай, Увс аймагт уулзвар, авто зам	5	28,589.4	25,789.8	-	-	-
Зам, уулзварын дүн		38	133,524.7	111,331.5	33	104,935.3	85,541.7
1	Зураг, төсөв	69	11,990.2	10,841.3	66	11,328.2	10,190.4
Зураг, төсвийн дүн		69	11,990.2	10,841.3	66	11,328.2	10,190.4
ЗАМ, УУЛЗВАР, ЗУРАГ, ТӨСВИЙН ДҮН		107	145,514.9	122,172.8	99	116,263.5	95,732.1
1	Зөвлөх үйлчилгээ болон захиалагчийн хяналт /Си Ти Ай Инженеринг Интернешнл ХХК/	1	11,371.4	7,970.0	1	11,371.4	6,232.4
2	Хүй 7 худаг дахь зөвлөх үйлчилгээ /Танил санаа ХХК/	1	77.6	76.1	1	77.6	76.1
Зөвлөх үйлчилгээний дүн		2	11,609.0	8,046.1	2	11,449.0	6,305.5
1	Төслийн нэгжийн үйл ажиллагааны зардал	1	6,029.0	6,029.0	-	-	-
2	Газар чөлөөлөлт, нөхөн олговор	4	402.9	402.9	4	402.9	402.9
Бусад дүн		5	6431.9	6431.9	4	402.9	402.9
НИЙТ ДҮН		114	163,555.8	136,650.8	105	128,115.4	102,443.5

¹ 2013 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн Монгол банкны ханшаар хөрвүүлэв. 1 ам.доллар = 1 398.55 төгрөг

Эх сурвалж: Сангийн яам, Хөгжлийн банк, Гудамж төслийн нэгж

“Гудамж” төслийн нэгжийн нийслэлд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнээс нийт үнийн дүнгийн 40% буюу 47 086.6 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий ажлыг гүйцэтгэж дууссан хугацаанаас хойш зураг төсвийн магадлалын дүгнэлт гарсан, нэмэлт гэрээ байгуулсан 20 авто зам, уулзварын ажлыг аудитын түүвэрт хамруулан шалгасан.

Үүнийг Хүснэгт №2-оор харуулбал:

Д/д	Төсөл, арга хэмжээний төрөл	Нийт		Үүнээс:		
		ажлын тоо	гэрээний дүн /сая.төг/	түүвэрт хамрагдсан ажлын тоо	гэрээний дүн /сая.төг/	олгосон санхүүжилт /сая.төг/
1	Уулзвар	22	41,648.4	17	30,219.1	27,932.1
2	Авто зам	5	47,907.4	3	16,867.5	11,805.9
3	Хүй 7 худаг орчмын авто зам, зогсоол	3	13,868.8	-	-	-
4	Гандантэгчилэн хийд орчмын гудамжны зам, барилга	3	1,510.7	-	-	-
5	Зураг, төсөв	66	11,328.2	-	-	-
	ДҮН	99	116,263.5	20	47,086.6	39,514.0

Эх сурвалж: Хөгжлийн банк, Гудамж төслийн нэгж

Аудитад хамруулсан 47 086.6 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 20 төсөл, арга хэмжээнээс 20 959.6 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 6 авто зам, уулзварын ажлын нэмэлт гэрээг байгуулахдаа нэгжийн өртөг, ажлын тоо хэмжээг үндэслэлгүй нэмэгдүүлсэн эсэхэд дүгнэлт гаргуулахаар ялгаж, түүнд мэргэжлийн шинжээчдийг татан оролцууллаа. Үүнд:

Хүснэгт №3

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн /сая.төг/	Олгосон санхүүжилтийн дүн /сая.төг/
1	Цэцэг төвийн уулзвараас "Корпорейт" зочид буудлын замтай холбох 0.45 км авто зам	2,249.5	2,158.2
2	Гэмтлийн эмнэлгийн баруун урд уулзвар, Ард аюушийн өргөн чөлөө, нэгдүгээр хорооллын арын зам, барилгын ажил	4,057.7	3,964.5
3	Баянгол дүүргийн 3,4 дүгээр хорооллын эхлэл Энэбишийн өргөн чөлөө, Ахуй үйлчилгээний зүүн урд уулзварын өргөтгөл шинэчлэлтийн ажил	6,119.6	5,485.7
4	ХУД, "Атар өргөө" ХХК-ийн урд замаас Яармагийн гүүр хүртэлх 1.2 км авто зам, барилгын ажил	4,204.1	4,074.7
5	ХУД, "Атар өргөө" ХХК-ийн урд замаас Яармагийн гүүр хүртэлх 1.0 км авто зам, барилгын ажил	1,895.5	1,840.9
6	Саппорогийн аюулгүйн тойргийн өргөтгөл, шинэчлэлтийн ажил	2,433.2	2,397.5
	ДҮН	20,959.6	19,921.5

Эх сурвалж: Хөгжлийн банк, Гудамж төслийн нэгж

ЗГ-ын 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 196 дугаар тогтоолоор “Гудамж” төслийн нэгжийг татан буулгаж “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийг байгуулжээ. Уг тогтоолын 3 дугаар зүйлд “Гудамж” төслийн нэгжийг татан буулгаж байгаатай холбогдуулан тус төслийн санхүүгийн тайлан балансад бүртгэлтэй хөрөнгө, өр авлагыг тооцоо нийлж, “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төсөлд балансаас балансад шилжүүлэх арга хэмжээ авахыг даалган, 5 дугаар зүйлд “Гудамж төслийн санхүүжилтийн тухай” ЗГ-ын 2013 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 81 дүгээр тогтоолоор “Гудамж” төсөлд хуваарилагдсан хөрөнгийг “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төсөлд шилжүүлэн санхүүжүүлэхийг зөвшөөрсөн тул энэхүү аудитын тайланд шалгагдагч байгууллагын саналыг дээрх төслийн нэгжээс авсан болно.

НЭГ. Төлөвлөлтийн үе шатны бэлтгэл ажил бүрэн хангагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх;

1.1. ЗГ-ын баталгаагаар бий болгосон Чингис бондын хөрөнгө нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8², Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3³, 6.3.4⁴ дэх заалтуудын дагуу төсвийн бүрэлдэхүүн болно.

ЗГ-ын 2013 оны 81 дүгээр тогтоолоор “Гудамж” төслийн эхний ээлжийн санхүүжилтийг ЗГ-ын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс Хөгжлийн банкаар дамжуулан 200.0 сая ам доллар буюу 279,710.0⁵ сая төгрөгтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр төсөл, арга хэмжээ тус бүрээр бус нийт дүнгээр баталсан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4⁶ дэх заалтыг зөрчжээ.

1.2. ЭЗХ-ийн сайд “Гудамж” төслийн нэгжийн 2013 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний нэр төрөл, төсөвт өртгийг тус бүрээр батлаагүй байхад тус яамны Төрийн нарийн бичгийн дарга нь уулзвар, авто зам, хурдны зам, гэр хороолол гэсэн дэд төслүүдийн санхүүжилтийн хуваарийг 286 000.0 сая төгрөгөөр баталсан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.5⁷ дахь заалтыг зөрчжээ. Энэ нь зураг, төсөв хийгдээгүй, төсөвт өртөг тодорхойгүй байсантай холбоотой.

1.3. 2014 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, нэр төрлийг ЭЗХ-ийн яамнаас батлаагүй байхад ТУХ-ны 2013 оны 81 дүгээр тогтоолоор төсөвт өртөггүй төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр ажлын ерөнхий төлөвлөгөөг баталж, мөрдөж ажилласан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.5 дахь заалтыг зөрчжээ.

Дээрх зураг төсөвгүй, төсөвт өртөггүй 31 ажлын төлөвлөгөөг хүснэгтээр харуулбал: Хүснэгт№4

	Төсөл, арга хэмжээний нэр	Батлагдсан төсөв
1	Саппорогийн аюулгүйн тойргийн өргөтгөл, шинэчлэлт	-
2	Бөхийн өргөөний арын уулзварын өргөтгөл, шинэчлэлт	-
3	Өргөө кино театрын урд уулзварын өргөтгөл, шинэчлэлт	-
4	Тээврийн дээд сургуулийн өргөтгөл, шинэчлэлт	-
6	Циркийн хойд уулзварын өргөтгөл, шинэчлэлт	-
7	10-р хорооллын уулзварын өргөтгөл, шинэчлэлт	-
8	Дарь эхийн уулзварын өргөтгөл, шинэчлэлт	-
9	ХУД, 19-р хорооллын NTV телевизийн арын уулзварын өргөтгөл, шинэчлэлт	-
10	Эрчим хүчний гудамж Ажилчны гудамжтай огтлолцох /гурвалжингийн гүүрний урд талд/ замын уулзварын өргөтгөл, шинэчлэлт	-
11	Дамбын хуучин эцсийн 3 замын уулзварын өргөтгөл, шинэчлэлт	-
12	Тасганы овооны уулзварын өргөтгөл, шинэчлэлт	-
13	Халдвартын баруун урд уулзварын өргөтгөл, шинэчлэлт	-
14	Гэмтлийн эмнэлгийн баруун урд уулзвар, Ард аюушийн өргөн чөлөө, нэгдүгээр хорооллын арын зам, барилгын ажил	-
15	25 дугаар эмийн сангийн уулзварын өргөтгөл, шинэчлэлт	-
16	3, 4 дүгээр хорооллын эцсийн уулзварын зам барилгын ажил гүйцэтгэх	-

² “ЗГ-ын дотоод, гадаад зээл, ... ЗГ-ын баталгаа, өрийн бичиг ...”-г “Улсын өр” гэнэ

³ “төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагааг төсөвт тусгах”

⁴ “Төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх”

⁵ 2013 оны 3 дугаар сарын 07 өдрийн Монгол банкны ханшаар хөрвүүлэв. 1ам.доллар=1,398.55 төгрөг

⁶ төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах;

⁷ төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн төвлөрүүлэн захирагч бүрээр, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагдахгүй төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах;

17	ХУД, “Атар өргөө” ХХК-ийн урд замаас “Дулааны 3-р цахилгаан станц”-ын урд уулзвар хүртэлх 1,2 км авто зам, барилгын ажил	-
18	“Дулааны 3-р цахилгаан станц”-ын урд уулзвараас Яармагийн гүүр хүртэлх 1,0 км авто зам, барилгын ажил	-
19	ХУД, “Дулааны 3-р цахилгаан станц”-ын урд 4 замын уулзварын өргөтгөл, шинэчлэлт	-
20	“Дулааны 3-р цахилгаан станц”-ын баруун хойд замаас урагшаа яармагийн гүүр хүртэлх 1,5 км зам, барилгын ажил	-
21	Моносын уулзвараас “Просолиуд” ХХК-ий бетон зуурмагийн үйлдвэр хүртэлх 2,5 км шинэчлэн засварлах авто зам, барилгын ажил	-
22	“Просолиуд” ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэрээс сонсголонгийн гүүр хүртэлх 2,625 км авто зам, барилгын ажил	-
23	Цэцэг төвийн уулзвараас “Корпорейт” зочид буудлын замтай холбох 0.45 км авто зам, барилгын ажил	-
24	Баянгол дүүргийн 3,4 дүгээр хорооллын эхлэл Энэбишийн өргөн чөлөө, Ахуй үйлчилгээний зүүн урд уулзварын өргөтгөл, шинэчлэлт	-
25	Ботаникаас Шархад чиглэлийн 6,6 км авто замын төгсгөлийн хэсэг буюу 2,36 км авто зам, барилгын ажил	-
26	БГД, Гандантэгчэнлин хийд Орхоны 6-р гудамжны зам барилга угсралтын ажил	-
27	Хан уул дүүргийн арын уулзварын өргөтгөл, шинэчлэлт	-
28	Ажилчны гудамж, ДЦС-3 араас баруун тийш Эрчим хүчний гудамжтай холбох 066 км авто зам, 72 м төмөр бетон гүүрийн барилга, угсралтын ажил	-
29	Үйлдвэрчний гудамжийг Москва хорооллын арын далангаар явуулж, Өнөр хорооллын 33-р байрны арын замтай холбох 1 км авто зам, Т хэлбэрийн дам нуруутай 18 у/м төмөр бетон 2 гүүрийн барилга, угсралтын ажил	-
30	БГД, 16-р хороо, Гандантэгчэнлин хийд, Орхоны 5 дугаар гудамжны гадна цэвэр ус, бохир ус, дулаан, цахилгаан, холбооны шугам сүлжээний ажил	-
31	БГД, 16-р хороо, Гандантэгчэнлин хийд, Орхоны 10 дугаар гудамжны гадна цэвэр ус, бохир ус, дулаан, цахилгаан, холбооны шугам сүлжээний ажил	-
	НИЙТ	-

Эх сурвалж: Гудамж төслийн нэгж

1.4. Монгол улсын 2015, 2016 оны Төсвийн тухай хуулийн 3 дугаар хавсралтаар батлагдсан Хөгжлийн банкны эх үүсвэрээр төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад “Гудамж” төслийн өмнөх онуудад дутуу хэрэгжсэн он дамжин Нийслэлд хэрэгжих уулзвар, авто зам, зураг төсвийн ажлуудын үлдэгдэл хөрөнгийг баталжээ.

Хүснэгт №5-аар харуулбал:

Төсөл, арга хэмжээний төрөл		Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг /сая.төг/	Санхүүжих дүн /сая.төг/
2015 он	Уулзвар, авто зам	10	72,935.2	30,072.6
	Зураг, төсөл	16	8,905.3	784.9
2015 онд Нийслэлд хэрэгжих нийт		26	81,840.5	30,857.5
2016 он	Уулзвар, авто зам	2	12,475.9	2,158.9
	Зураг, төсөл	2	1,644.2	243.0
2016 онд Нийслэлд хэрэгжих нийт		4	14,120.1	2,401.9

Эх сурвалж: Монгол Улсын 2015, 2016 оны Төсвийн тухай хууль

2013, 2014 онд зураг төсөвгүй, батлагдсан төсөвт өртөггүйгээр төсөл, арга хэмжээнүүдийн нэр төрлийг төлөвлөн баталснаар уулзвар, авто замын ажлын зураг төсвийг нөхөж боловсруулахад хугацаа алдах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах болон гүйцэтгэлийн явцад хүндрэл бэрхшээл учруулах, ажлын тоо хэмжээ, төсөвт өртөг өөрчлөгдөх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгосон.

ХОЁР. Сонгон шалгаруулалтыг холбогдох хууль журмын дагуу явуулсан эсэх;

2.1. "Гудамж" төслийн нэгж нь 2013-2016 оны хооронд нийслэлд 91 066.5 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 30 уулзвар, авто замын ажил, 11 328.2 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 66 зураг төсөв, 160.0 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 1 хуулийн зөвлөх үйлчилгээ, 11 371.4 сая төгрөг /гэрээ байгуулсан өдрийн ханшаар тооцсон/-ийн гэрээний үнэ бүхий 1 зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлж, тэдгээрт захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулжээ.

Харин НАЗХГ 13 868.9 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий “Хүй 7 худаг орчмын авто зам, зогсоол”-ын 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

2.2. "Гудамж" төслийн нэгж нь гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн 3 дугаар зүйлийн 3.6⁸ болон Монгол Улсын Хөгжлийн банкны тухай /тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан/ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1⁹ дахь заалтуудыг үндэслэн ЭЗХ-ийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар баталсан “Хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан ЗГ-ын үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах түр журам” /цаашид “түр журам” гэх/-ыг баримталжээ.

ЭЗХ-ийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар баталсан түр журам нь захиргааны хэм хэмжээний актаар бүртгэгдээгүй нь Засгийн газрын 119 дүгээр тогтоолоор батлагдсан Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журмыг зөрчжээ. Иймд тус түр журмыг эрх зүйн чадамжгүй гэж үзэж байна.

Дээрх түр журмыг баримталж төслийн нэгжийн захирлын 2013 оны 13 дугаар тушаал, ТУХ-ны 2014 оны 35 дугаар тогтоолоор “Сонгон шалгаруулалтын журам, болон Үнэлгээний хуудас, үнэлгээний нэгдсэн дүнгийн загвар”-ыг баталсан.

Сонгон шалгаруулалтын журам, загварыг боловсруулахдаа ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах бус, харин зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийн жишиг баримт бичгийг ашигласан нь батлагдсан төсөвт өртөггүй ажилд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж улмаар санхүүгийн болон техникийн чадавхгүй, ажлын туршлагагүй компани шалгарах нөхцөлийг бүрдүүлсэн гэж үзэж байна.

Аудитаар ЭЗХ-ийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар баталсан түр журмыг шалгуур болгон түүвэрт хамрагдсан төсөл, арга хэмжээнүүдийн гүйцэтгэгчийг шалгаруулсан тендерийн материалуудыг шалгахад 9 185.6 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 6 төсөл, арга хэмжээнд ТБОНӨХБАҮХАТХуулийн 14; 15; 16 дугаар зүйлүүдийн шаардлагад нийцээгүй гүйцэтгэгчийг шалгаруулсан зөрчил илэрлээ. /Хавсралт №1/

Тухайлбал:

- “Циркийн хойд уулзварын авто зам, барилга”-ын 849.6 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий ажилд тухайн чиглэлээр ажил гүйцэтгэж байгаагүй, туршлагагүй, үндсэн ажилтангүй, машин механизмын хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, сүүлийн 2 жилд үйл ажиллагаа явуулаагүй, “Х” тайлан гаргаж байсан “Велдедлайне Монголиа” ХХК-ийг;
- “Өргөө кино театрын урд уулзварын авто зам, барилга”-ын 1 590.5 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий ажилд хатуу хучилттай авто зам барих тусгай зөвшөөрөлгүй, татварын өртэй “Паблицроуд” ХХК-ийг;
- “10 дугаар хорооллын уулзварын авто зам, барилга”-ын 1 247.9 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий ажилд татварын өртэй, санхүүгийн тайлангаас харахад нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй, үндсэн ажилтангүй “Скай стар” ХХК-ийг;
- “Саппорогийн аюулгүйн тойргийн авто зам, барилга”-ын 2 433.2 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий ажилд тендерийн баримт бичигт заасан татварын тодорхойлолт, хугацаа

⁸ Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

⁹ Хөгжлийн банк дараах үйл ажиллагааг эрхэлнэ. 7.1.1.зээл олгох, авах, ... 7.1.7.хөрөнгө өр төлбөрийн зүй зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа.

хоцорсон зээлийн өргүй талаарх харилцагч банкны тодорхойлолт ирүүлээгүй “Наранбулаг Хан” ХХК-ийг өртэй эсэхийг магадлаагүй;

- “Дулааны 3 дугаар цахилгаан станцын урд 4 замын уулзварын авто зам, барилга”-ын 1 168.9 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий ажилд тендерийн баримт бичигт заасан сүүлийн 3 жилийн тайланг баталгаажуулсан аудитын дүгнэлт ирүүлээгүй, санхүүгийн тайлангаас харахад үндсэн хөрөнгөгүй, нийгмийн даатгалын шимтгэл төлдөөгүй, үндсэн ажилтангүй “Рок Пэйнт ХХК”-ийг;
- “Дулааны 3 дугаар цахилгаан станцын урд уулзвараас яармагийн гүүр хүртэлх 1,0 км авто зам, барилга”-ын 1 895.6 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий ажилд тендерийн баримт бичигт заасан татварын тодорхойлолт, хугацаа хоцорсон зээлийн өргүй талаарх харилцагч банкны тодорхойлолт ирүүлээгүй, үндсэн ажилтан болохыг нотлох баримтгүй “Мон роуд” ХХК-ийг өртэй эсэхийг магадлаагүй шалгаруулжээ..

Дээрхи зөрчилтэй компаниудыг сонгон шалгаруулсан тухайн үеийн Төслийн удирдах хороог хууль хяналтын байгуулагад шилжүүлэн шалгуулах шаардлагатай.

2.3. ТУХ-ноос “Гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай” тогтоол гаргахаас өмнө 8 053.3 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий дараах төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулалгүй ажлыг нь эхлүүлж, Барилгын тухай /тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан/ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1¹⁰ дэх заалтуудыг зөрчжээ. Үүнд:

- “Дулааны 3 дугаар цахилгаан станцын баруун хойд замаас урагшаа яармагийн гүүр хүртэлх 1,5 км зам” барилгын 6 884.4 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий ажил;
- “Дулааны 3 дугаар цахилгаан станцын урд 4 замын уулзвар”-ын зам барилгын 1 168.9 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий ажилд гэрээ байгуулах тухай зөвшөөрөл 2013 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр гарсан боловч 2013 оны 8 дугаар сарын 15-ны өдөр тус тус гэрээ байгуулаагүй, ТУХ-ны шийдвэргүйгээр ажлыг эхлүүлсэн.

¹⁰ Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материал үйлдвэрлэх, зураг төсөл зохиогч, хөрөнгө оруулагчаас чанарын хяналт тавих, худалдан борлуулахтай холбогдсон ажиллагааг гэрээгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

ГУРАВ. Ажил гүйцэтгэх гэрээг холбогдох хууль, журамд нийцүүлэн байгуулж, магадлал хийгдэж, баталгаажсан зураг төсвөөр ажлыг гүйцэтгэсэн эсэх;

3.1. "Гудамж" төслийн нэгж нь нийслэлд нийт 116 263.5 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий уулзвар, авто замын 33, зураг төсөл боловсруулах 66 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулжээ.

Дээрх төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх явцдаа Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹¹ болон Барилгын тухай /*тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан*/ хуулийн 13 дугаар зүйлийн 13.2¹², 13.5¹³ дахь заалтуудыг зөрчиж 43 526.5 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 18 төсөл, арга хэмжээнд магадлал хийлгээгүй зураг төсвөөр авто зам, замын байгууламжийн ажлыг хийж гүйцэтгэжээ. /Хавсралт № 2/

Жишээлбэл: 2 433.2 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий “Саппорогийн аюулгүйн тойргийн өргөтгөн шинэчлэх ажил”-ыг авч үзэхэд 2013 оны 6 дугаар сарын 3-ны өдрөөс 2013 оны 6 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл хийж гүйцэтгэсэн байна. Ингэхдээ зураг төсвийн зохиогч “Танил санаа” ХХК зураг төсвийг боловсруулж, 2013 оны 8 дугаар сарын 24-ний өдөр захиалагчид хүлээлгэн өгсөн нь ажлыг зураг төсөвгүй гүйцэтгэн Барилгын тухай /*тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан*/ хуулийн 16 дугаар зүйлийн 16.2¹⁴ дахь заалтыг зөрчжээ.

Дээрхи зураг, төсөвт магадлал хийлгэж баталгаажсаагүй, төсөвт өртөг тодорхойгүй ажлуудад гэрээний нийтлэг үндэслэлийн 1.3 “*Энэхүү гэрээний нийт үнийн дүн нь ажлын нийт санхүүжилтийн эхний ээлжийн санхүүжилт байна*” заалтыг үндэслэн урьдчилгаа санхүүжилтийг “нийт гэрээний үнийн дүн” мэтээр 13 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулж ажлыг эхлүүлж, зураг, төсөв баталгаажсаны дараагаар нийт төсөвт өртгийг үндэслэн нэмэлт гэрээ байгуулсан байна.

Хүснэгт №6-аар харуулбал:

№	Уулзвар, замын нэр	Гүйцэтгэгч байгууллага	Анхны болон нэмэлт гэрээ байгуулсан огноо	Анхны гэрээн дээрх урьдчилгаа санхүүжилт ийн дүн	Нэмэлт гэрээн дээрхи нийт санхүүжилт ийн дүн /нийт гэрээний дүн/	Нэмэлт гэрээг эр гэрээн ий дүн нэмэгдсэн хувь	Нийт олгосон санхүүжилт
1	3, 4 дүгээр хорооллын эцсийн уулзвар	"Паблицроуд" ХХК	2013.08.27, 2013.10.21	300.0	1,356.8	352%	1,274.3
2	ХУД, "Дулааны 3-р цахилгаан станц"-ын урд 4 замын уулзвар	"Рок Пэйнт" ХХК	2013.09.20, 2013.10.10	400.0	1,168.9	192%	1,076.7
3	10-р хорооллын уулзвар	"Скай стар" ХХК	2013.08.09, 2013.08.29	300.0	1,247.9	316%	1,199.9
4	Бөхийн өргөөний арын уулзварын зам барилгын ажил	"Төгс үржих зам" ХХК	2013.08.09, 2013.08.29	250.0	985.9	294%	885.5

¹¹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

¹² Гадаадын зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх, эсхүл газар хөдлөлтийн 6-гаас дээш баллын бүсэд баригдах, барилга байгууламжийн зураг төсөл, инженер-геологийн төвөгшилтэй нөхцөлийн судалгааны дүгнэлт, техник, эдийн засгийн үндэслэлд магадлал заавал хийлгэнэ.

¹³ Энэ хуулийн 13.2, 13.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгээгүй тохиолдолд барилгын ажил эхлэхийг хориглоно.

¹⁴ Барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

5	Эрчим хүчний гудамж Ажилчны гудамжтай огтлолцох замын уулзвар	"Цүүрдэн" ХХК	2013.08.09, 2013.08.29	250.0	875.1	250%	854.9
6	Циркийн хойд уулзвар	"Велдедлайн е Монголиа" ХХК	2013.09.20, 2013.12.13	280.0	849.6	203%	818.0
7	Гэмтлийн эмнэлгийн баруун урд уулзвар, Ард аюушийн өргөн чөлөө, нэгдүгээр хорооллын арын зам барилга	"Экспресс зам" ХХК	2013.09.12, 2013.12.13	2,000.0	4,057.8	103%	3,964.5
8	"Дулааны 3-р цахилгаан станц"-ын урд уулзвараас Яармагийн гүүр хүртэлх 1,0 км авто замын зам барилга	"Мон роуд" ХХК	2013.09.20, 2013.12.13	440.0	1,895.6	331%	1,840.9
9	ХУД, "Атар өргөө" ХХК-ийн урд замаас "Дулааны 3-р цахилгаан станц"-ын урд уулзвар хүртэлх 1,2 км авто замын зам барилга	"Наранбулаг хан" ХХК	2013.09.20, 2013.12.13	800.0	4,204.1	426%	4,074.7
10	"Дулааны 3-р цахилгаан станц"-ын баруун хойд замаас урагшаа яармагийн гүүр хүртэлх 1,5 км зам барилга	"Эрдэнэ зам" ХХК	2013.12.16, 2014.08.01, 2015.07.06	113.0	6,884.4	5992%	5,890.3
11	Цэцэг төвийн уулзвараас Төрийн тусгай хамгаалалттай газрын хашаа дайруулан Сөүлийн гудамжтай холбох авто зам, уулзвар	"Экспресс зам" ХХК	2014.06.05, 2015.07.06	955.4	2,249.5	135%	2,158.2
12	Баянгол дүүргийн 3,4 дүгээр хорооллын эхлэл Энэбишийн өргөн чөлөө, Ахуй үйлчилгээний зүүн урд уулзварын өргөтгөл шинэчлэлтийн авто зам	"Наранбулаг Хан" ХХК	2014.07.04, 2015.07.06	3,388.5	6,119.6	81%	5,610.3
13	Дарь эхийн уулзвар	"Экспресс зам" ХХК	2013.07.05, 2013.12.13	1,370.7	1,398.7	2%	1,204.1
НИЙТ ДҮН				10,847.6	33,294.0	207%	30,852.4

Эх сурвалж: Үндэсний аудитын газрын судалгаа

3.2. Аудитын явцад 20 959.6 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 6 авто зам, барилгын ажлын нэмэлт гэрээг байгуулахдаа нэгжийн өртөг, ажлын тоо хэмжээг үндэслэлгүй нэмэгдүүлсэн эсэхэд дүгнэлт гаргуулахаар Төрийн аудитын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2¹⁵ дахь заалтыг үндэслэн ЗТХЯ, НМХГ, НАЗХГ-аас мэргэжлийн шинжээч, гэрээт төсөвчдийг татан оролцуулж ажиллуулсан. Гэвч дараах шалтгаанаас үүдэн тодорхой дүгнэлт гаргах боломжгүй байна.

Газар дээр нь хийгдсэн ажлын бодит тоо хэмжээг гүйцэтгэлийн төсөвтэй харьцуулан авч үзэж асфальт бетон хучилтын хэмжээг гүйцэтгэлийн зурагт зааснаар тооцож болох ч харин ажлын үнэ өртгийн ихэнх хэсгийг өөртөө агуулдаг хөлдөлтөөс хамгаалах үе, цементээр бэхжүүлсэн суурь зэрэг, далд ажлуудын хувьд зарим зураг төсөв байхгүй, далд ажлын актад ажлын тоо хэмжээ тавигдаагүй зэрэг шалтгаанаас ажлын бодит тоо хэмжээ буюу уулзвар, авто замын нийт төсөвт өртгийг тодорхойлох боломжгүй байна гэж шинжээчид, гэрээт төсөвчид үзэж байна.

3.3. “Гудамж төсөл”-ийн нэгжийн хэрэгжүүлж байгаа нийт төсөл, арга хэмжээний гэрээтэй холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянуулахаар 2013 оны 5 дугаар сарын 16-ны өдөр “Парита энд Партнерс” ХХК-тай 160.0 сая төгрөгийн үнэ бүхий “Хууль, эрх зүйн зөвлөгөө үзүүлэх” гэрээ байгуулж, төслийн нэгжид гэрээний төслүүд болон хууль тогтоомжийг мөрдөж ажиллах талаар санал зөвлөмж хүргүүлжээ.

¹⁵ Монгол Улсын Ерөнхий аудитор бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ гадны шинжээч, мэргэжилтнийг аудитын үйл ажиллагаанд татан оролцуулж, үйлчилгээ, зөвлөгөө авч болно.

Аудитад хамрагдсан авто зам, барилгын ажил гүйцэтгэх компаниудтай байгуулсан гэрээг хянан үзэхэд гэрээний хариуцлагын заалтууд нь тодорхойгүй, зарим заалтууд нь холбогдох хуультай зөрчилдсөн гэрээ байгуулжээ

Тухайлбал:

- Гэрээний тусгай нөхцлийн 48-д “Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн дүнгийн 0.5 хувь байна” гэж заасан нь Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.6¹⁶-д заасныг зөрчсөн;
- Гэрээний тусгай нөхцлийн 1.1-д “Магадлашгүй ажлын зардлыг гэрээний нийт үнийн дүнгийн 2 хувьтай тэнцүү хэмжээгээр тооцож ажлын төсөвт өртөгт оруулна” гэж заасан нь ЗТБХБ-ын сайдын 2011 оны 200 дугаар тушаалаар баталсан “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв зохиох заавар”-ын 1.5.4.3¹⁷ дахь заалтыг зөрчсөн. Улмаар энэ нь магадлашгүй ажлын зардал нэмэгдэх нөхцлийг бүрдүүлсэн байна;
- Гэрээний тусгай нөхцлийн 55.2-д “Гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан актыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ 1.0 сая төгрөгөөр торгох” заалт нь ямар хугацаанд ирүүлэхийг гэрээнд тодорхой тусгаж өгөөгүйгээс хэрэгжээгүй;
- Гэрээний тусгай нөхцлийн 28-д “Гүйцэтгэгч гэрээ байгуулснаас хойш 2 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана, тодотгосон ажлын хөтөлбөрийг хугацаанд нь ирүүлээгүй тохиолдолд 1.0 сая төгрөгөөр торгох” заалт нь гэрээг огноогүй байгуулсан, тодотгосон ажлын хөтөлбөрийг хэзээ хүлээлгэж өгсөн нь тодорхойгүй зэргээс шалтгаалан хэрэгжээгүй байна.

Мөн хууль, зүйн зөвлөгөө үзүүлсэн байгууллагаас хууль тогтоомжийг мөрдөж ажиллах талаарх өгсөн санал зөвлөмжийг үйл ажиллагаандаа бүрэн мөрдөөгүйгээс хуулийн зөвлөгөө үзүүлсэн байгууллагын ажлын үр дүнг хангалтгүй болгожээ.

Тухайлбал:

- 5 271.6 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий дараах 3 жилд огноогүй гэрээ байгуулсан нь ТУХ-оос гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрээс өмнө гэрээ байгуулсан эсэхийг хянах боломжгүй болгосон;
 - o “Саппорогийн аюулгүйн тойргийн өргөтгөн шинэчлэлтийн ажил”;
 - o “Өргөө кино театрын урд уулзварын ажил”;
 - o “10 дугаар хорооллын уулзварын ажил”;
- Нийт 26 618.1 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 12 уулзвар, авто замын ажлын гүйцэтгэгч нь ажил дуусах хугацааг 19-106 хоногоор хэтрүүлсэн нь гэрээний хугацаанд бусад хүчин зүйлийн нөлөөг тооцоогүйг харуулж байна; /Хавсралт № 3/
- “Гэмтлийн эмнэлгийн баруун урд уулзварын ажил”-ын зураг төсвийг хийж гүйцэтгэсэн “ХЗТ Авто зам” ХХК-тай байгуулсан гэрээг ажил хүлээлгэн өгөх өдөр байгуулж, гэрээгүйгээр ажлыг гүйцэтгэжээ.

¹⁶ Хууль болон гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр тогтоосон анзыг алданги гэнэ.

¹⁷ Нэгдсэн төсөвт тусгах “Магадлашгүй ажил”-ын зардал нь Сангийн сайд, дэд бүтцийн хөгжлийн сайдын 1996 оны 12 дугаар сарын 31-ний 406 дугаар хамтарсан тушаалын хавсралтын дагуу барилга угсралтын ажлын төсөвт нэгтгэх талбайн төсөв тус бүр (ажилчдын хээрийн нэмэгдлийг оролцуулсан дүн)-ийн 2 %-иас ихгүй байна.

ДӨРӨВ. Төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлд захиалагчийн болон зохиогчийн хяналт тавьж, санхүүжилтийг хууль, журмын дагуу олгосон эсэх;

4.1. “Гудамж” төслийн нэгж нь зөвлөх үйлчилгээ болон захиалагчийн хяналтыг “Си Ти Ай Инженеринг Интернейшнл” ХХК-тай 7.9 сая ам.долларын гэрээ байгуулан гүйцэтгүүлжээ.

Ингэхдээ хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллагын зардлыг тусгаагүй байсан бөгөөд бондын хөрөнгөөс хяналтын зөвлөх үйлчилгээ дансаар 6 232.4 сая төгрөгийн санхүүжилт олгожээ. Иймд төслийн нэгжид хяналтын төсөвт суусан захиалагчийн хяналтын зардлыг олгоогүй байна.

ЗГ-ын 2010 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Барилгын зураг, төсөл боловсруулах, түүнд магадлал хийх, барилгын үе шатны ажилд хяналт тавих, ашиглалтад оруулах хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэх дүрэм”-ийн 10.1¹⁸ дэх заалтыг зөрчиж, тухайн төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт тусгаагүй, мөн дүрмийн 1.3¹⁹ дахь заалтыг зөрчиж зөвлөх үйлчилгээний эрхгүй компаниар захиалагчийн хяналтыг хийлгэсэн нь Барилгын тухай хуулийн /*тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан*/ 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт “барилгын хөрөнгө оруулагч нь захиалагчийн болон зөвлөх үйлчилгээг барилгын мэргэжлийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно” гэсэн заалт болон Засгийн Газрын 2012 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”, гэрээний холбогдох заалтуудыг зөрчжээ.

Түүвэрт хамрагдсан ажлуудаас дараах зөрчил илэрлээ.

Гэрээний тусгай нөхцлийн 50-д зааснаар “Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний үнийн дүнгийн 5 хувиас доошгүй дүнтэй байна. Гүйцэтгэлийн баталгаа нь үл маргах нөхцөлтэй банкных байх ба санхүүжүүлэгчийн заасан маягтын дагуу байна” гэсэн заалтыг зөрчиж гүйцэтгэлийн баталгаа гаргуулаагүйгээр ажлыг гүйцэтгүүлсэн;

- *“Дарь-Эхийн уулзварын өргөтгөл шинэчлэлтийн ажил”-ын гүйцэтгэлийг хянахгүйгээр баталгаажуулснаас 168.7 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон;*
- *4 449.5 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 2 төсөл, арга хэмжээний нэмэлт гэрээний магадлалын ерөнхий дүгнэлт гараагүй байхад 369.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүнд:*
 - o *“Тээврийн дээд сургуулийн урд уулзварын ажил”-д хяналтын төсөв 235.1 сая төгрөгөөр баталгаажсан боловч 391.7 сая төгрөгөөр гэрээ байгуулан, 290.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон;*
 - o *“Гэмтлийн эмнэлгийн баруун урд уулзварын ажил”-д хяналтын төсөв 3 650.8 сая төгрөгөөр баталгаажсан боловч 4 057.8 сая төгрөгөөр гэрээ байгуулан, 3 964.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон.*
- *Барилгын тухай /тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан/ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1²⁰ дэх заалтыг зөрчиж, гэрээ байгуулахаас өмнө ажлыг эхлүүлсэн зөрчил илэрсэн. Үүнд:*
 - o *14 676.4 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 10 ажлыг гэрээ байгуулахаас өмнө эхлүүлсэн; /Хавсралт №4/*
 - o *1,209.3 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий “Зуун айлын уулзварын барилга угсралтын ажил”-д нэмэлт гэрээ байгуулах зөвшөөрлийг Хөгжлийн банкнаас олгоогүй байхад 340.7 сая төгрөгийн ажлыг сонгон “Паблицроуд” ХХК-иар гүйцэтгүүлсэн нь Барилгын тухай /тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан/ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтыг зөрчсөн нь хууль хяналтын байгууллагад шилжүүлэх шаардлагатай байна.*

Мөн НЕТГазрын тухайн үеийн холбогдох албан тушаалтнууд эрх мэдлээ хэтрүүлэн ЗГ-ын 2012 оны 151 дүгээр тогтоолоор баталсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх,

¹⁸ Хөрөнгө оруулагч нь зөвлөх үйлчилгээний зардлыг зах зээлийн тухай үеийн ханшаар нарийвчлан тооцох бөгөөд төслийн төсөвт өртгийн 5 хувиас багагүй тооцож, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт тусгана.

¹⁹ Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх нь барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлснээр үүснэ.

²⁰ Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материал үйлдвэрлэх, зураг төсөл зохиогч, хөрөнгө оруулагчаас чанарын хяналт тавих, худалдан борлуулахтай холбогдсон ажиллагааг гэрээгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1.2.1²¹-д заасныг зөрчиж, магадлал хийгдээгүй зураг төсөлтэй ажилд барилгын ажил эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосныг хууль хяналтын байгуулагад шилжүүлэн шалгуулах шаардлагатай.

4.2. “Си Ти Ай Инженеринг Интернейшнл” ХХК нь “Гудамж” төслийн хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнд зураг төсөв зохиохоос эхлэн зам, барилгын ажил дуусах хүртэлх хугацаанд зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа, төслийн нэгжид захиалагчийн хяналтын зардлыг олгодоггүй зэргээс зураг төслийн зохиогчтой хяналтын гэрээг байгуулаагүй байна.

Дээрх асуудал нь Барилгын тухай /тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан/ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3²², Дэд бүтцийн сайдын 1999 оны 196 тоот тушаалаар баталсан “Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийх” дүрмийн 1.3²³, 1.9²⁴-д заасныг болон ЗГ-ын 2009 оны 73 дугаар тогтоолоор баталсан “Барилгын захиалагчийн дүрэм”-ийн 3.1.7²⁵-д заасныг тус тус зөрчжээ. Үүнээс шалтгаалж ажлыг зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй байх, зохиогчийн шийдвэргүйгээр өөрчлөх, улмаар зохиогчийн эрх, үүрэг, хариуцлагыг сулруулсан байна.

4.3. Нийслэлд 2013-2016 онд хэрэгжүүлсэн уулзвар, авто зам, зураг төсвийн 116 263.5 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 99 ажилд 95 732.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Үүнийг хүснэгт №7-оор үзүүлбэл:

Д/д	Төсөл, арга хэмжээний төрөл	Нийт ажлын тоо	Гэрээний дүн /сая.төг/	Нийт олгосон санхүүжилт /сая.төг/	Үүнээс: Олгосон санхүүжилт /сая.төг/		
					2013, 2014 онд	2015 онд	2016 онд
1	Уулзвар	22	41,648.4	30,504.5	26,703.8	3,800.7	-
2	Авто зам	5	47,907.4	40,601.3	20,943.3	17,499.1	2,158.9
3	Хүй 7 худаг орчмын авто зам, зогсоол	3	13,868.8	13,290.4	13,290.4	-	-
4	Гандантэгчилэн хийд орчмын гудамжны зам барилга	3	1,510.7	1,145.5	1,145.5	-	-
5	Зураг, төсөв	66	11,328.2	10,190.4	9,171.6	785,0	233.8
	ТӨСЛИЙН ДҮН	99	116,263.5	95,732.1	71,254.6	22,084.8	2,392.7

Эх сурвалж: Хөгжлийн банк, Гудамж төслийн нэгж

4.4. Нийслэлд хэрэгжүүлсэн авто зам, уулзварын ажлуудаас 2013-2016 онд нийт 146.3 сая төгрөгийн норм, нормативын зардлыг авто замын санд төвлөрүүлж, 4 890.4 сая төгрөгийг Хөгжлийн банк барьцаанд суутгасан байна.

Аудитад хамрагдсан ажлуудаас 32 004.3 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий ажилд гэрээний тусгай нөхцлийн 47-д “Барьцаа хөрөнгийн хувь нь гэрээний нийт үнийн дүнгийн 5 хувь байна” заалтыг зөрчиж, гэрээний нийт үнийн дүнгээс бус гарсан гүйцэтгэлээс тооцож 120.1 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг дутуу суутгасан байна. /Хавсралт № 5/

²¹ “Барилгын ажлыг эхлүүлэх” гэж Барилгын тухай хуулийн 13.2, 13.3-т заасны дагуу барилгын норм, нормативын баримт бичгийг баримтлан боловсруулж, магадлал хийсэн зураг төслөөр баригдах барилга, байгууламжийн ажлыг гүйцэтгэх хуулийн этгээдэд барилгын ажил эхлүүлэх, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг.

²² Энэ хуулийн 15.1.2-т заасны дагуу барилгын явцад зохиогчийн хяналт тавих.

²³ Зохиогчийн хяналтыг инженерийн хийцтэй бүх төрлийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралт, хот тосгон хорооллын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажилд өмчийн хэлбэр, хөрөнгө оруулалтын эх үүсвэр хэмжээг харгалзахгүйгээр заавал хийлгэсэн байна.

²⁴ Зохиогчийн хяналтыг барилгын захиалагч, зураг төслийн байгууллагын хороонд аж ахуйн гэрээг байгуулах үндсэн дээр хийнэ...

²⁵ Барилгын ажлын үе шат бүрт зохиогчийн хяналтыг гүйцэтгүүлэх.

4.5. Мөн 22 338.9 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 12 авто зам, уулзварын ажилд 2016 онд батлагдсан Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3²⁶ дахь заалтыг үндэслэн гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулалгүй 1,023.8 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг 8-606 хоногийн өмнө чөлөөлжээ. /Хавсралт №6/ Үүнээс шалтгаалж чанарын баталгаат хугацааны гэрээний үүргийн хэрэгжилтийг хангалтгүй болгожээ.

ТАВ. Төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг холбогдох эрх зүйн актын дагуу ашиглалтад хүлээн авч, данс бүртгэлд тусгасан эсэх.

5.1. Нийслэлд “Гудамж” төслийн нэгжийн хэрэгжүүлсэн зам, барилгын ажлуудаас 2013-2016 онд 90 062.4 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 29 ажлыг ашиглалтад оруулсан.

Ашиглалтад оруулах комисс нь дээрх ажлуудыг “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4.13.9²⁷ дэх заалтыг зөрчиж, зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт гараагүй байхад хүлээн авч, түүвэрт хамрагдсан ажлуудаас 16 229.7 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 6 ажлыг дээрх дүрмийн 4.12.1²⁸ дэх заалтыг зөрчиж, зураг, төсөв нь баталгаажуулаагүй байхад ашиглалтад хүлээн авчээ.

Аудитад хамрагдсан ажлуудаас 37 963.4 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 18 ажилд “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4.12.7²⁹ дахь заалтыг зөрчиж, комисс ажилласнаас хойш 14 хоногт багтаан комиссын актыг баталгаажуулаагүй, дахин комисс ажиллуулаагүй нь барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комисс үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, хариуцлагагүй ажилласны нотолгоо юм. /Хавсралт №7/

5.2. Комисс ажиллаж, ашиглалтад хүлээн авсан 88 853.1 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 28 уулзвар, авто замыг өмчид бүртгүүлэх хүсэлт гаргасан. Үүнээс:

- 41 297.4 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 20 уулзвар, авто замыг НИТХ-ын 2017 оны 4 дүгээр тогтоолоор нийслэлийн өмчид өртгөөр³⁰ нь /зураг төсөв, зөвлөх үйлчилгээ, хяналтын камерын зардлыг нэмсэн/ 44 772.0 сая төгрөгөөр бүртгэсэн.
- 47 555.7 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 8 уулзвар, авто замыг 45 076.6 сая төгрөгөөр бүртгүүлэхээр 2017 оны 3 дугаар сарын 23-ны өдөр “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслөөс хүсэлтийг НӨХГ-т хүргүүлсэн боловч нийслэлийн өмчид бүртгэх шийдвэр гараагүй;
- 1 209.3 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий “Зуун айлын уулзварын зам, барилгын ажил”-д 340.7 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт шийдэгдээгүй шалтгаанаар нийслэлийн өмчид бүртгүүлэх хүсэлт хүргүүлээгүй байна.

Ийнхүү 9 уулзвар, авто замыг өмчид бүртгээгүй байгаа нь хөрөнгийн арчлалт, хамгаалалт буурах эрсдэлтэй байна.

Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комисс үүргээ бүрэн хэрэгжүүлэлгүй, хариуцлагагүй ажиллаж, 9 уулзвар, авто зам нийслэлийн өмчид бүртгэгдээгүй байна.

²⁶ Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна.

²⁷ Комисс ажиллах үед зураг төсөл зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлтийг зураг төслийн байгууллагын хамт гаргаж, биелэлтийг хангуулах.

²⁸ Комисс нь Барилгын тухай хууль, барилгын норм, нормативын бичиг, баримтад заасан шаардлагыг хангасан барилга байгууламжийг ашиглалтад оруулах үүрэг хүлээнэ.

²⁹ Комиссын гишүүд мэргэжлийнхээ чиглэлээр илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулсны дараа энэхүү дүрмийн 2 дугаар хавсралтад заасан актаг гарын үсэг зурж баталгаажуулна. Зөрчил дутагдлыг 14 хоногт бүрэн арилгасан байна. Комиссын актыг баталгаажуулаагүй тохиолдолд комисс дахин ажиллах бөгөөд үүнтэй холбогдож гарах зардлыг захиалагч хариуцна.

³⁰ НББОУС-ын 16.15 “Үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан хөрөнгүүдийг өртгөөр үнэлж бүртгэнэ” НББОУС-ын 16.16 “Өртгийн бүрэлдэхүүн хэсгүүд Дараах зүйлсийг үндсэн хөрөнгийн өртөгт багтаан авч үзнэ. Үүнд: б) Хөрөнгийг ашиглах байрлалд авчрах ба ашиглахад бэлэн болгохтой холбоотой шууд зардлууд өртөгт орно.”

Дүгнэлт:

1. “Гудамж” төслийн үйл ажиллагаа эхнээсээ зураг төсөвгүй, төсөвт өртөг нь тодорхойгүй, төлөвлөлтийн бэлтгэл ажил хангагдаагүй төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөжээ.
2. Аудитад хамрагдсан төсөл арга хэмжээнүүдэд ТБОНӨХБАҮХАТХуулийн зарим сонгон шалгаруулалтанд тавигдах шаардлагад нийцээгүй буюу захиргааны хэм хэмжээний актад бүртгэгдээгүй, эрх зүйн чадамжгүй “Хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан ЗГ-ын үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах түр журам”-ыг мөрдөж ажиллажээ.
3. Ажлын үнэ өртгийн ихэнх хэсгийг өөртөө агуулдаг далд ажлуудын актад ажлын тоо хэмжээ тавигдаагүйгээс шалтгаалан ажлын бодит тоо хэмжээ буюу уулзвар, авто замын нийт төсөвт өртгийг тодорхойлох, улмаар нэгжийн өртөг, ажлын тоо хэмжээг үндэслэлгүй нэмэгдүүлсэн эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй байна.
4. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрхгүй компаниар зөвлөх үйлчилгээ болон захиалагчийн хяналтыг гүйцэтгүүлсэн нь гүйцэтгэлд тавих хяналтыг хангалтгүй болгож хууль, дүрэм, журам, гэрээний холбогдох заалтыг зөрчжээ. Зураг төслийн зохиогчтой хяналтын гэрээг хууль дүрмийн дагуу байгуулалгүйгээр ажлыг гүйцэтгүүлсэн нь төсөл, арга хэмжээг зургын дагуу гүйцэтгэхгүй байх, зохиогчийн шийдвэргүй өөрчлөлт оруулах нөхцлийг бүрдүүлж, зохиогчийн эрх, үүрэг, хариуцлагыг сулруулсан байна
5. Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комисс үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй, хариуцлагагүй ажилласны улмаас 9 уулзвар, авто зам нийслэлийн өмчид бүртгэгдээгүй байна.

Зөвлөмж

Сангийн сайдад:

- ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.6-д “Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэсэн заалтын хүрээнд бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохицуулсан хууль эрх зүйн орчиныг боловсронгуй болгох;
- ЭЗХ-ийн сайдын 2013 оны 29 дүгээр тушаалаар баталсан “Хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан ЗГ-ын үнэт цаасны хөрөнгөөр санхүүжүүлэх, төслийг хэрэгжүүлэхэд баримтлах түр журам” нь захиргааны хэм хэмжээний актад бүртгэлгүй бөгөөд эрх зүйн чадамжгүй байх тул хүчингүй болгох;
- “Гудамж” төслийн асуудал Сангийн яаманд шилжсэн тул магадлал хийлгээгүй, баталгаажсан зураг төсөвгүй ажлыг төлөвлөж батлахгүй байх;
- Хуулийн шаардлага хангаагүй компаниудыг сонгон шалгаруулсан төслийн Удирдах хороо, Хөгжлийн банкны зөвшөөрөлгүй ажил гүйцэтгэсэн Паблицроуд ХХК, эрх мэдлээ хэтрүүлэн магадлал хийгдээгүй зураг төсөв нь баталгаажаагүй ажилд ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын холбогдох албан тушаалтануудыг хууль хяналтын байгуулагаар шалгуулахад анхаарч ажиллах;

Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын даргад:

- Магадлал хийлгээгүй зураг төсөвтэй ажилд “Барилгын ажлын зөвшөөрөл”-ийг олгохгүй байх;
- Хуулийн шаардлага хангасан, батлагдсан зураг төсвийн дагуу ажлыг гүйцэтгэсэн, зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт гарсан зохих журмын дагуу иж бүрэн байдлаар ажлуудыг ашиглалтад хүлээн авч байх;
- Хуулийн шаардлага хангаагүй компаниудыг сонгон шалгаруулсан төслийн Удирдах хороо, Хөгжлийн банкны зөвшөөрөлгүй ажил гүйцэтгэсэн Паблицроуд ХХК, эрх мэдлээ хэтрүүлэн магадлал хийгдээгүй зураг төсөв нь баталгаажаагүй ажилд ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын холбогдох албан тушаалтануудыг хууль хяналтын байгуулагаар шалгуулахад анхаарч ажиллах;

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргад:

- “Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийн нэгжээс нийслэлийн өмчид бүртгүүлэхээр хүсэлт гаргасан 8 авто зам, уулзварын ажлыг бүртгэх.
- Хуулийн шаардлага хангаагүй компаниудыг сонгон шалгаруулсан төслийн Удирдах хороо, Хөгжлийн банкны зөвшөөрөлгүй ажил гүйцэтгэсэн Паблицроуд ХХК, эрх мэдлээ хэтрүүлэн магадлал хийгдээгүй зураг төсөв нь баталгаажаагүй ажилд ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын холбогдох албан тушаалтануудыг хууль хяналтын байгуулагаар шалгуулахад анхаарч ажиллах;

“Хөгжлийн хөтөч-дэд бүтэц” төслийн нэгжийн захиралд:

- Ажил гүйцэтгэх гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгуулж, баталгаажсан зураг төсвөөр ажлыг гүйцэтгүүлж байх;
- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллагаар захиалагчийн хяналтыг гүйцэтгүүлэн, зохиогчийн хяналтын гэрээ байгуулж, гүйцэтгэлийн үе шатны хяналтыг сайжруулах;
- “Зуун айлын уулзварын авто зам барилгын ажил”-ыг НӨХГ-т өмчид бүртгүүлэх хүсэлт гаргаж шийдвэрлүүлэх;
- Хуулийн шаардлага хангаагүй компаниудыг сонгон шалгаруулсан төслийн Удирдах хороо, Хөгжлийн банкны зөвшөөрөлгүй ажил гүйцэтгэсэн Паблицроуд ХХК, эрх мэдлээ хэтрүүлэн магадлал хийгдээгүй зураг төсөв нь баталгаажгаагүй ажилд ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын холбогдох албан тушаалтануудыг хууль хяналтын байгуулагаар шалгуулахад анхаарч ажиллах;

Шалгагдагч байгууллагын санал:



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ

ХӨГЖЛИЙН ХӨТӨЧ ДЭД БҮТЭЦ ТӨСӨЛ

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо,
ЖСамбуугийн гудамж, М-плаза 14-р давхар,
1401 тоот, Утас: 7000-2555, Факс: 7000-3555

2017-05-10 № 183
танай _____-ны № _____-т

Тайлбар хүргүүлэх тухай

Танай ирүүлсэн тайлангийн төсөлтэй танилцаад, дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1. “Батлагдсан зураг төсөвгүй, төсөвт өртөг нь тодорхойгүй төсөл, арга хэмжээнүүдийг төлөвлөн баталжээ. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дах заалтыг зөрчсөн” гэжээ.

Засгийн газрын 2013 оны “Гудамж төсөл”-ийг батлах тухай 46-р тогтоолоор Гудамж төслийн хүрээнд хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөж баталсан. Уг бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхэд зураг төсөл боловсруулах ажлаас эхлэн, зам барилга угсралтын ажлуудыг гүйцэтгэхээр тусгасан. 2014 онд хэрэгжих зураг төсөл боловсруулах ажил, зам барилгын ажлын төлөвлөгөөг Төслийн удирдах хороогоор батлуулан хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 29.4 дах заалтыг зөрчсөн үндэслэл болохгүй.

Төслийн хүрээнд 2013-2014 онд хэрэгжүүлсэн ажлын санхүүжилт Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бус Засгийн газрын 2013 оны 81-р тогтоолоор батлагдсан Чингис бондын эх үүсвэрээр санхүүжсэн тул Төсвийн тухай хуулиар зохицуулагдахгүй байсан.

Харин, Төсвийн тухай хуульд 2015 оны 2 сарын 18-ны өдөр нэмэлт өөрчлөлт орж, дээрх харилцааг 2015 оны 2 сарын 18-ны өдөр батлагдсан Өрийн удирдлагын тухай хуулиар тус тус зохицуулахаар шийдвэрлэсэн. Энэ хууль батлагдсанаас хойш төсвийн тухай хуулийг баримтлан ажилласан.

2. 6 ажилд тендерийн баримтад заасан шалгуурыг хангаагүй гүйцэтгэгчийг шалгаруулсан нь илэрсэн. Тухайлбал, Велдедлайне Монголиа, Пабликроуд ХХК, скай стар ХХК, рок пэйнт ХХК, Наранбулаг хан, Монроуд ХХК.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 3.6-д “Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй”, мөн ЭЗХС-ын 2013 оны 29-р тушаалаар баталсан дээрх журмын 6.4.5, 11.2, 7.2.1-д заасны дагуу 2-оос доошгүй этгээдийг Төслийн удирдах хороо (ТУХ 9 яамны удирдах албан тушаалтнуудын төлөөллөөс бүрдсэн)-нд танилцуулж шийдвэрлүүлдэг.

Эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн шаардлагыг бүрэн хангасан, зам барилгын ажлын тусгай зөвшөөрөлтэй эдгээр компаниуд нь ажлыг гэрээний дагуу чанартай, хугацаанд нь гүйцэтгэсэн. Үүнийг шалгуур хангаагүй гэж үзэх нь үндэслэлгүй байна.

00311

Өргөө кино театрын урд уулзварыг гүйцэтгэсэн Паблицроуд ХХК нь хатуу хучилттай авто замын тусгай зөвшөөрөлтэй КТК ХХК-тай түншлэлээр хамтран оролцсон болно.

3. ТУХ гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай тогтоол гарахаас өмнө гэрээ байгуулсан хоёр ажил. /Эрдэнэ зам ХХК, Рокпэйнт ХХК/

Дээрх 2 ажлын гэрээг ТУХ-ноос гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай тогтоол гарсны дараа гэрээг байгуулсан болно. Үүнд:

1. ТУХ-ны 2013 оны 9-р сарын 10-ны өдрийн 71-р тогтоолоор “Дулааны 3 дугаар цахилгаан станцын баруун хойд замаас урагшаа Яармагийн гүүр хүртэлх 1,5 км зам барилгын ажил”-ын гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон. Уг тогтоолыг үндэслэн “Гудамж” төсөл, Хөгжлийн банк, гүйцэтгэгч “Эрдэнэ зам” ХХК-тай 2013 оны 12-р сарын 16-ны өдөр С-ГТ-Б 2013-191 тоот гэрээг байгуулсан байна.
2. ТУХ-ны 2013 оны 9-р сарын 10-ны өдрийн 68-р тогтоолоор “Дулааны 3 дугаар цахилгаан станцын урд 4 замын уулзварын ажил”-ын гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон. Уг тогтоолыг үндэслэн “Гудамж” төсөл, Хөгжлийн банк, гүйцэтгэгч “Рокпэйнт” ХХК-тай 2013 оны 09-р сарын 20-ны өдөр С-ГТ-Б 2013-160 тоот гэрээг байгуулсан байна.

4. 3 ажилд огноогүй гэрээ байгуулсан. /Саппоро, Өргөө, 10-р хороолол/

Ажил гүйцэтгэх гэрээг 3 хувь үйлдэж, огноо, дугаарыг Хөгжлийн банкнаас олгож, бичилт хийдэг. Төслийн нэгжид хүргүүлсэн гэрээний нэг хувь дээр огноог орхигдуулсан байна. Гүйцэтгэгч болон Хөгжлийн банк дахь гэрээний нэг хувь дээр Саппорогийн аюулгүйн тойргийн ажил гүйцэтгэх гэрээг 2013 оны 6 сарын 10-ны өдрийн С-ГТ-Б 2013-76 дугаар, 10 дугаар хорооллын уулзварын ажил гүйцэтгэх гэрээг 2013 оны 8 сарын 09-ны өдөр С-ГТ-Б 2013-133 дугаар гэрээ байгуулсан байна. /Хөгжлийн банк дахь гэрээний хуулбарыг хавсаргав./

5. Магадлал хийлгэж баталгаажсан хяналтын төсөөс давсан үнийн дүнгээр гэрээ байгуулсан. /Тээврийн дээд сургуулийн урд уулзвар, Гэмтлийн эмнэлэгийн урд уулзвар/

Тээврийн дээд сургуулийн уулзварын ажлын зураг төслийг “Мөнхийн тод зам” ХХК боловсруулсан. Энэ ажлын зургийн байгууллагаар баталгаажсан төсөвт өртөг 395,3 сая төгрөг. Үүнээс гэрээ байгуулсан дүн 391,7 сая төгрөг, гүйцэтгэлээр санхүүжсэн дүн нь 290,9 сая төгрөг болсон.

Ард Аюушийн өргөн чөлөө, 1-р хорооллын арын замтай огтлолцсон дөрвөн замын уулзварын ажлын зураг төслийг боловсруулах ажлыг “ХЗТ” ХХК гүйцэтгэсэн. Зургийн байгууллагын баталгаажуулсан төсөвт өртөг 4 217,04 сая төгрөг. Үүнээс гэрээ байгуулсан дүн 4 057,8 сая төгрөг, гүйцэтгэлээр санхүүжсэн дүн нь 3 964,5 сая төгрөг болсон.

6. Нийт 12 уулзвар, замын ажлын гүйцэтгэгч нь ажил дуусах хугацааг 19-106 хоногоор хэтрүүлсэн нь гэрээний хугацааг бодитой тооцоогүй, бусад хүчин зүйлийн нөлөөг тооцоогүйг харуулж байна. Хавсралт 1.3

Дээрх 12 ажлаас зөвхөн 1 ажил тухайн гүйцэтгэгч компаниас хамаарч хугацаандаа хийгдээгүй гэж үзэж, алданги тооцсон. Бусад ажлууд нь гүйцэтгэгч компаниудаас шалтгаалж хугацаа хэтрүүлсэн асуудал байхгүй.

Улсын комисс ажиллуулах, бичиг баримт бүрдүүлэхэд хугацаа шаардлагатай байдаг тул үүнийг гэрээнд заасан “ажил гүйцэтгэх” хугацаанд оруулан тооцдоггүй.

Гэтэл аудитын тайлангийн төсөлд Улсын комисс ажилласан хугацаа болон гэрээ дүгнэсэн хугацааг гэрээт “ажил гүйцэтгэх” хугацаанд оруулан тооцож, хугацаа хоцорсон гэх хоногийг тооцож гаргасан байгааг хүлээн зөвшөөрөх үндэслэлгүй байна.

7. Аудитын түүвэрт хамрагдсан ажлуудаас Төсвийн тухай хуулийн 29-р зүйлийн 29.4 болон тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Барилгын тухай хуулийн 13.2, 13.5 дах заалтуудыг зөрчиж 43,526.5 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 18 ажилд магадлал хийлгээгүй зураг

төслөөр авто зам, замын байгууламжийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Хавсралт 1.4. Мөн авто замын уулзварын ажлыг зураг төсөөгүй гүйцэтгэсэн нь тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдгөж байсан Барилгын тухай хуулийн 16.2 дах заалтыг зөрчсөн байна.

Гудамж төслийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлуудыг магадлал хийгдэж баталгаажуулсан зураг төслийг үндэслэн гүйцэтгүүлсэн. Зарим ажлын зураг төслийг ЗГ-ын 2009 оны 204-р тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм”-ийн 2.1, 2.2, 6.1-д заасны дагуу хоёр үе шатаар боловсруулсан.

Энэ дүрмийн 6.1-д “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн боловсруулсан зураг төслийн нүүр хуудсанд гарын үсэг зурж, тэмдэг даран баталгаажуулна.” гэж заасан.

Үүний дагуу анхан шатны зураг төсөл буюу баталгаажсан зураг төслийг үндэслэн Гудамж төсөл, Хөгжлийн банк, гүйцэтгэгч компанитай зам барилгын ажил гүйцэтгэх гурвалсан гэрээг урьдчилгаа олгох үнийн дүнгээр байгуулж, ажлыг эхлүүлсэн.

Хоёр дах шатны зураг төсөл бүрэн гарч магадлалаар баталгаажуулсны дараа гэрээний нийт үнийн дүнтэй нэмэлт гэрээ байгуулан, магадлалаар баталгаажсан зураг төсөлд үндэслэн ажлыг гүйцэтгүүлсэн нь хууль, тогтоомж зөрчсөн үндэслэл болохгүй юм.

8. “...харин хөлдөлтөөс хамгаалах үе, цементээр бэхжүүлсэн суурь, бусад далд ажлуудын хувьд зарим зураг төсөө байхгүй, далд ажлын актад ажлын тоо хэмжээ тавигдаагүй зэрэг шалтгаанаас бодит тоо хэмжээг тодорхойлох боломжгүй” гэж дүгнэжээ.

ҮАГ, АТГ, ЗТХЯ, НАЗХГ, НМХГ, Гудамж төсөл, хяналтын зөвлөх, гүйцэтгэгчийн удирдлага, инженер техникийн ажилтнуудын төлөөлөл оролцсон багийн хамтарсан талбай дээрхи хэмжилт, шалгалтын үед НАЗХГ-ын итгэмжлэгдсэн лаборатори нь корын /сорьц авах/ машинаар замын хучилтыг ерөмдөхөд асфальтбетон хучилтын доод үе цементээр бэхжүүлсэн суурь нь хатуу бэхжсэн, өрөм дийлэхгүй байсан тул оролцсон хүмүүс гүйцэтгэлийн зурагт зааснаар шаардлага хангаж байна гэж үзсэн.

Мөн Барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч компани нь зураг төслийн дагуу гүйцэтгэж байсан бөгөөд БУА-ын явцад зургийн зохиогч, хяналтын зөвлөх, Гудамж төслийн нэгж, гүйцэтгэгч нарын хамтарсан үзлэг, хяналт хийгдэж тухайн ажлын үе шат бүрд тоо хэмжээг далд ажлын акт, зөвшөөрлийн хуудсаар баталгаажуулдаг, мөн итгэмжлэгдсэн лаборатори /НАЗГ-ын, ЛАБО ХХК, Кэй эйч ти эс ХХК /-оос хяналт шалгалт хийж байсан, ажлын зураг төсөл нь магадлангийн ерөнхий дүгнэлтээр баталгаажсан. Мөн 2013-2016 онд БУА-ын үед ЗТХЯ, МХЕГ, НМХГ, ХБ, НАГ-аас хяналтууд хийгдэж байсан болно.

9. Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналт хангалтгүй болсон байна. Тухайлбал, Дарь эхийн уулзварын өргөтгөл шинэчлэлтийн ажлын гүйцэтгэлийг хянахгүйгээр баталгаажуулснаас 168.7 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон.

Гудамж төслөөс Хөгжлийн банкинд 2015 оны 07 сарын 06-ны өдрийн 383 тоот албан бичигт Экспресс зам ХХК-ийн хийж гүйцэтгэсэн “Дарь эхийн уулзвар”-ын өргөтгөл шинэчлэлтийн ажилд гарсан зөрүүг залруулан, тус компанийн гүйцэтгэсэн “Цэцэг төвийн уулзвар”-ын ажлын санхүүжилтээс суутган тооцсон тул илүү олгоогүй. /Санхүүжүүлэгч болон гүйцэтгэгч байгууллагын санхүүгийн баримтаас харж болно./

10. Зураг төслийн зохиогчтой хяналтын гэрээг байгуулаагүй нь тухайн үед мөрдөгдөж байсан Барилгын тухай хуулийн 17.1.3, Дэд бүтцийн сайдын 1999 оны 196 тоот тушаалаар Барилгын ажлын явцад

зохиогчийн хяналт хий дүрмийн 1.3, 1.9-д заасныг болон Засгийн газрын 2009 оны 73-р тогтоолоор баталсан Барилгын захиалагчийн дүрмийн 3.1.7-д заасныг тус тус зөрчжээ. Үүнээс шалтгаалж ажлыг зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй байх, зохиогчийн шийдвэргүйгээр өөрчлөх, улмаар төсөвт өртөг нэмэгдэх зэрэг эрсдлийг бий болгож, зохиогчийн эрх, үүрэг, хариуцлагыг сулруулсан байна.

2008 оны Барилгын тухай хуулийн 15.1.2-д зааснаар захиалагч нь Барилгын ажлын явц, чанарт хяналт тавих, фото зургаар баримтжуулсан ил, далд ажлын акт, барилгын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах, мөн хуулийн 15.1.6-д барилгын зураг төсөл, барилгын ажилд хөндлөнгийн хяналт хийлгэх эрхтэй.

Энэхүү Барилгын тухай хуулийн 15.1.2, 15.1.6 дах заалт болон Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийх дүрмийн 1.7-д заасны дагуу зохиогчтой зөвшилцөж Си ти ай инженеринг интернэйшнл компантай зураг төсөл боловсруулахаас эхлэн, барилгын ажил дуусах хүртэл хугацаагаар хяналт хийлгэх гэрээг энэхүү дүрмийн 1.6-д заасны дагуу байгуулсан. Энэ нь Зураг төсөл боловсруулах компанитай байгуулсан гэрээний 2.8-д хяналт болон зөвлөх үйлчилгээний гэрээний 5.1-д зааснаар зохицуулагдаж байна.

Барилгын ажлын явцад хяналтын зөвлөх, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, захиалагч талууд хяналт тавьж, асуудлыг тухай бүр хамтран шийдвэрлэж байсан нь гүйцэтгэлийн баримт, тэмдэглэл материалаас харагдаж байгаа тул зохиогчийн эрх, үүрэг, хариуцлагыг сулруулсан гэж үзэх үндэслэлгүй байна.

11. Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналт хангалтгүй болсон байна.

Олон улсын хяналтын зөвлөх эрхтэй, Монгол улсад бүртгэлтэй, Монгол улсад хийгдсэн томоохон бүтээн байгуулалт болох Нарны гүүр, нарны зам барилгын ажилд зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай Си ти ай инженеринг интернэйшнл компани барилгын ажлын талбайд байнгын хяналтыг хэрэгжүүлсэн.

Гудамж төслийн инженер техникийн ажилчид ажлын талбайд биечилсэн болон камераар тогтмол хяналт тавьсаны үр дүнд төслийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлуудад зөрчил дутагдлыг тухай бүр илрүүлж, газар дээр нь засаж залруулж ажилласан тул хяналтыг хангалтгүй болсон гэж үзэхгүй байна.

12. Автозам, уулзварын ажлуудаас 22,338.9 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 12 ажилд 2016 онд батлагдсан Барилгын тухай хуулийн 14.3 дахь заалтыг үндэслэн 1,023.8 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг чөлөөлсөн байна. Энэ нь гэрээнд ямар нэгэн өөрчлөлт ороогүй байхад гэрээний тусгай нөхцлийн 35-д “Чанарын баталгаат хугацаа 3 жил байна”, 47-д “Барьцаа хөрөнгийг чанарын баталгаат хугацаа дуусах хүртэлх хугацаанд санхүүжүүлэгч баталгаа хөрөнгө болгон үлдээнэ” заалтуудыг зөрчиж 8-606 хоногийн өмнө барьцаа хөрөнгийг чөлөөлж, гүйцэтгэгчид олгожээ.

2016 оны Барилгын тухай хуулийн 14.3 дах заалт, “Барилга, хот байгуулалтын яам”-ны 2016 оны 3-р сарын 28-ны өдрийн 02/818 албан тоотыг үндэслэн төслийн нэгжээс барьцаа хөрөнгө чөлөөлүүлэх тухай хүсэлт, гэрээний төслийг Хөгжлийн банкинд 2016 оны 03-р сарын 28-ны өдрийн 101 тоот албан бичгээр хандсан. Санхүүжүүлэгч байгууллага болох Хөгжлийн банкнаас гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэж, барьцааг чөлөөлсөн.

13. 34,905.5 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 8 ажлыг бүртгэх шийдвэр гараагүй, 1209.3 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий 100 айлын уулзварын зам, барилгын ажлын нэмэлт санхүүжилт шийдэгдээгүй шалтгаанаар өмчид бүртгүүлэх хүсэлт гаргаагүй байна. Дээрх 9 ажлыг өмчит бүртгээгүй, эзэнжүүлээгүй байгаа нь хөрөнгийн арчлалт, хамгаалалт буурах, бий болсон хөрөнгө оруулалт эзэнгүйдэх эрсдлийг бий болгож байна.

Дээрх 8 ажлын санхүүжилт нь удааширч, 2017 оны 2 дугаар сар хүртэл үргэлжилсэн. Өнөөдрийн байдлаар зарим ажлын санхүүжилт бүрэн хийгдэж дуусаагүй байна. Санхүүжилт бүрэн дууссан нөхцөлд ажлыг өмчид балансаас балансад хүлээлгэн өгөхөөр хүлээгдэж байгаа болно.

Засгийн газрын 2016 оны 196-р тогтоолоор Гудамж төслийг татан буулгахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан уг ажлуудыг өмчид бүртгүүлэх хүсэлтийг Нийслэлийн Өмчийн Харилцааны газарт 2017 оны 03-р сарын 23-ны өдрийн 101 тоот албан бичгээр хүргүүлээд байна.

Дээрх ажлуудын баталгаат хугацаа дуусаагүй тул жил бүр дээрх авто замууд дээр захиалагч, гүйцэтгэгчийн хамтарсан үзлэг шалгалт хийж, арчлалтыг гүйцэтгэгч хариуцан ажиллаж байна.

Холбогдох материалыг хавсралтаар хүргүүлэв.

ДЭД ЗОХИЦУУЛАГЧ



Б.БАТБОЛД

Үндэсний Аудитын газрын тайлбар:

1. ЗГ-ын баталгаагаар бий болгосон бондын хөрөнгө нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.8 дахь "ЗГ-ын дотоод, гадаад зээл, ... ЗГ-ын баталгаа, өрийн бичиг ..." -г "Улсын өр" гэнэ", Төсвийн тухай хуулийн 6.3.3 дахь "төсвийн орлогоор баталгаажсан Засгийн газрын баталгаа, зээл, бүх төрлийн санхүүгийн үүрэгтэй холбогдсон гэрээ, хэлцэл, үйл ажиллагааг төсөвт тусгах", 6.3.4 дэх "Төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх" заалтуудын дагуу төсвийн бүрэлдэхүүн болох тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй.
2. Өргөө кино театрын урд уулзварын ажлын тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд *“хатуу хучилттай авто зам барих тусгай зөвшөөрөлтэй байх”* гэж заасан байхад түншлэлийн гэрээтэй “КТК” ХХК нь тусгай зөвшөөрөлтэй эсэх нь нотлогдохгүй, шалгарсан гүйцэтгэгчийн материал тусгай зөвшөөрлийг хавсаргаагүй байна. Бусад 5 ажил дээр ирүүлсэн тайлбар ажил дууссанаас хойш үйл явцын талаарх тайлбар ирүүлсэн тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
3. “Гэрээ байгуулж” гэдгийг “гэрээ байгуулаагүй ажлыг эхлүүлсэн” гэж тайланд өөрчлөлт орууллаа.
4. “Гудамж” төслийн нэгжээс баримт материалыг татаж үзэхэд гэрээнд ямар нэгэн огноо байгаагүй бөгөөд энэ нь төслийн нэгжийн хариуцлагагүй үйлдлийн талаар бичигдсэн байгаа тул тайланд нэмэлт оруулах шаардлагагүй.
5. Дээрх ажлуудад зургийн байгууллагаар баталгаажсан төсөвт өртөг бус магадлал хийгдсэн төсөвт өртгийн талаар бичигдсэн тул хамааралгүй тайлбар ирүүлсэн гэж үзэн тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй.
6. Дээрх ажлуудад "Улсын комисс ажилласан" болон "Гэрээг дүгнэсэн" хугацааг хамруулаагүй бөгөөд гүйцэтгэгчээс "Ажил дууссан тухай мэдэгдэл" ирүүлсэн өдрөөр тооцож гаргасан болно. Хавсралтад "Дууссан буюу ажил дуусах мэдэгдэл ирүүлсэн огноо" гэж тодорхой заасан болно. Иймд тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй.
7. Барилгын тухай */тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан/* хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 " Гадаадын зээл, тусламж, улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх, эсхүл газар хөдлөлтийн 6-гаас дээш баллын бүсэд баригдах, барилга байгууламжийн зураг төсөл, инженер-геологийн төвөгшилтэй нөхцөлийн судалгааны дүгнэлт, техник, эдийн засгийн үндэслэлд магадлал заавал хийлгэнэ", 13.5 "Энэ хуулийн 13.2, 13.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгээгүй тохиолдолд барилгын ажил эхлэхийг хориглоно" гэж тодорхой заасан байхад "анхан шатны зураг төсөл буюу баталгаажсан зураг төслийг үндэслэн ажлыг эхлүүлсэн" гэж тайлбар ирүүлсэн тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй.
8. НМХГ-аас томилогдсон ажлын хэсгийн дүгнэлтээс " *Далд ажлын актад ажлын тоо хэмжээ тавигдаагүй*" нь нотлогдсон, аудитын явцад холбогдох нотлох баримтуудыг НМХГ-аас томилогдсон шинжээчдэд нэмж гаргаж өгөөгүй тул тайланд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагагүй.
9. Гүйцэтгэлийг хянахгүйгээр баталгаажуулж, илүү санхүүжилт олгосон, дараа нь өөр ажил буюу "Цэцэг төвийн уулзвар"-ын ажлаас суутгаж авсан нь зөрчил гаргаагүй гэж үзэх үндэслэл болохгүй тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй.
10. Барилгын тухай */тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан/* хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3-т "Энэ хуулийн 15.1.2-т заасны дагуу барилгын явцад зохиогчийн хяналт тавих", Дэд Бүтцийн сайдын 1999 оны 196 тоот тушаалаар баталсан *“Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийх”* дүрмийн 1.3-т “Зохиогчийн хяналтыг инженерийн хийцтэй бүх төрлийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралт, хот тосгон хорооллын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажилд өмчийн хэлбэр, хөрөнгө оруулалтын эх үүсвэр хэмжээг харгалзахгүйгээр заавал

хийлгэсэн байна”, 1.9-д “Зохиогчийн хяналтыг барилгын захиалагч, зураг төслийн байгууллагын хороонд аж ахуйн гэрээг байгуулах үндсэн дээр хийнэ...” гэж заасныг болон ЗГ-ын 2009 оны 73 дугаар тогтоолоор баталсан “Барилгын захиалагчийн дүрэм”-ийн 3.1.7-д “Барилгын ажлын үе шат бүрт зохиогчийн хяналтыг гүйцэтгүүлэх” гэж заасныг тус тус зөрчиж зохиогчийн эрх, үүрэг, хариуцлагыг сулруулсан ба дээрх хууль журмуудыг зөрчсөн учир дээрх тайлбарыг хүлээн авах боломжгүй.

11. Гүйцэтгэлийг хянахгүйгээр баталгаажуулж, илүү санхүүжилт олгосон, ЗГ-ын 2010 оны 185 дугаар тогтоолоор баталсан “Барилгын зураг, төсөл боловсруулах, түүнд магадлал хийх, барилгын үе шатны ажилд хяналт тавих, ашиглалтад оруулах хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэх дүрэм”-ийн 1.3 “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх нь барилгын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлснээр үүснэ” заалтыг зөрчиж зөвлөх үйлчилгээний эрхгүй компаниар хяналтыг гүйцэтгүүлсэн, зохиогчийн хяналтын гэрээ байгуулаагүй, зохиогчийн хяналтын дүгнэлт гаргаагүй зэрэг нь хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд тавих захиалагчийн болон зохиогчийн хяналт хангалтгүй болсныг харуулж байгаа тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй.
12. Барилгын тухай хууль өөрчлөгдсөнтэй холбоотой гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байсан ч оруулаагүй барьцаа хөрөнгийг чөлөөлсөн нь гэрээг зөрчиж, чанарын баталгаат хугацааны гэрээний үүргийн хэрэгжилтийг хангалтгүй болгож байгаа тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй.
13. Дээрх тайлбарын талаар тайланд тусгагдсан байгаа тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Гудамж төслийн нэгжийн сонгон шалгаруулалт явуулсан ажлуудын худалдан авах ажиллагаанд гарсан зөрчлийн судалгаа

Хавсралт №1

Д / Д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Гэрээний дүн /сая.төг/	Гүйцэтгэгч байгууллагын нэр	Үндсэн үйл ажиллагааны чиглэл тохирохгүй буюу тусгай зөвшөөрөл авч ажилбаруудыг байгууллагын нягтлан	Тусгай зөвшөөрлийн зөрчлэлт	Сүүлийн 3 жилийн хугацаанд жил төстэй ажил хийж гүйцэтгэсэн ажлын туршлагыг харуулах тайлан, том хэмжээний ажлын гэрээ эсхүл ажлын үйлчилгээний төсөл, хөндөг, үйлдвэр, ажлын гэрээний хангамжийг хангах	Тонг төхөөрөмж, машин механизм, шаардлагыг хангауу /жасах/	Сүүлийн 3 жилийн баталгаажуулсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт ирүүлээгүй, ирүүлсэн боловч хангалтгүй	Хугацаа хоцорсон зээлийн өргүй талаарх харилцааг банкны талаарх харилцааг банкны хугацаа хоцорсон зээлийн өртэй байх магадлалтай компанийг шалгаруулсан	Татварын газрын тодорхойлолт ирүүлээгүй, эсвэл өртэй	Ажлын аргачлал ирүүлээгүй, ирүүлсэн боловч хангалтгүй	Зөрчлийн тайлбар	дүн
1	Циркийн уулзварын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах ажил	849.6	Велдelaide монголиа ХХК	1	1	1	1	1	1	1	1	Авто замын ажлын туршлага байхгүй цахилгааны ажил гүйцэтгэж байсан ажлын гэрээ ирүүлсэн, 2013 оны 4 сард тусгай зөвшөөрөлтэй болсон компани Учир ижил төрлийн ажлын туршлагагүй, санхүүгийн тайлангаас харахад үндсэн ажилтангүй, 15 том оврын автомашины гэрчилгээ ирүүлсэн боловч бүгд хуурамч /зарим нь компани байгуулагдахаас өмнө машина авснаар баримт бүрдүүлсэн, компьютерээр зассан/, ажлын аргачлал ирүүлээгүй, санхүүгийн Х тайлан гаргаж байсан, харилцааг банкны тодорхойлолт ирүүлээгүй	7
2	Өргөө кино театрын урд уулзвар	1,590.5	Пабликруд ХХК,	1				1	1	1		Татварын өртэй , хатуу хучилттай зам барих тусгай зөвшөөрөлгүй, 2011 оны аудитын дүгнэлт ирүүлээгүй буюу үйл ажиллагаа явуулаагүй компанийг шалгаруулсан	4
3	10 дугаар хорооллын уулзвар	1,247.9	Скай стар ХХК	1	1					1		Татварын өртэй, санхүүгийн тайлангаас харахад нийгмийн даатгалын төлбөр төлдөггүй буюу үндсэн ажилтангүй, үйл ажиллагааны чиглэл тохирохгүй буюу тусгай зөвшөөрөл авсан ч байгууллагын гэрчилгээнд нэмэлт хийлгээгүй компанийг шалгаруулсан	3
4	Саппорогийн аюулгүйн тойргийн өргөтгөн шинэчлэлт	2,433.2	Наранбулаг Хан ХХК						1	1		Тендерийн баримт бичигт заасан татварын тодорхойлолт ирүүлээгүй, хугацаа хоцорсон зээлийн өртүй талаарх харилцааг банкны тодорхойлолт ирүүлээгүй буюу татварын болон банкны хугацаа хоцорсон зээлийн өртэй байх магадлалтай компанийг шалгаруулсан	2
5	ХУД, ДЦС III-ын урд 4 замын уулзвар	1,168.9	Рок Пэинт ХХК			1						Тендерийн баримт бичигт заасан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланг баталгаажуулсан аудитын дүгнэлт ирүүлээгүй, санхүүгийн тайлангаас харахад үндсэн хөрөнгөгүй, нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй буюу үндсэн ажилтангүй компанийг шалгаруулсан	2

6	“Дулааны 3-р цахилгаан станц”-ын урд уулзвараас Фармацийн гүүр хүртэлх 1,0 км авто замын зам барилгын ажил	1,895.5	“Мон роуд” ХХК						1						1	1		1	1	1	Үндсэн ажиглалт болохыг нотлох баримт байхгүй, Тендерийн баримт бичигт заасан хугацаа хоцорсон зээлийн өргүй талгаарх харилцагч банкны тодорхойлолт ирүүлээгүй, татварын газрын тодорхойлолт ирүүлээгүй буюу өртэй байх магадлалтай компанийг шалгаруулсан	3
Нийт		9,185.6		2	1	1	1	4	1	3	4	4	4	1	1	1	1	1	1	1	21	

Магадлал хийлгээгүй зураг төсвөөр ажлыг гүйцэтгэсэн зөрчлийн судалгаа

Хавсралт №2

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний үнийн дүн /сая.төг/	Гэрээгээр ажил гүйцэтгэх хугацаа		Зураг, төсөвт магадлал хийсэн			Тайлбар
				Эхлэх огноо	Дуусах огноо	Зураг хийсэн компанийн нэр	Анхны зураг, төсөвт магадлал хийсэн огноо	Нэмэлт ажлын зураг, төсөвт магадлал хийсэн огноо	
1	Саппорогийн аюулгүйн тойргийн өргөтгөл шинэчлэлт	"Наранбулаг Хан" ХХК	2,433.2	2013.06.03	2013-06-20	Танил санаа ХХК	2013.09.17	-	Гэрээ дүгнэсэн протоколд ажлыг гэрээт хугацаандаа дууссанаар дүгнэсэн
2	Бөхийн өргөөний арын уулзварын зам барилгын ажил	"Төгс үржих зам" ХХК	985.9	2013.07.22	2013-08-20	Танил санаа ХХК	2013.09.17	2015.11.09	Гэрээ дүгнэсэн протоколд ажлыг гэрээт хугацаандаа дууссанаар дүгнэсэн
3	Өргөө кино театрын урд уулзвар	"Пабликроуд" ХХК	1,590.5	2013.05.27	2013-06-10	Ти Ай Би ХХК	2013.07.10		Төсөвт одоог хүртэл магадлал хийгдээгүй байна.
4	Тээврийн дээд сургууль /хуучнаар Төмөр замын дээд сургууль/	"Дагшин харуй" ХХК	391.7	2013.06.10	2013.07.01	Мөнхийн тод зам ХХК	2013.10.25	-	Гэрээ дүгнэсэн протоколд ажлыг гэрээт хугацаанаас 6 хоноогоор хэтрүүлсэнээр дүгнэсэн
5	10-р хорооллын уулзвар	"Скай стар" ХХК	1,247.9	2013.07.08	2013.08.20	Ар Си Эс Си ХХК	2013.08.29	-	Гэрээ дүгнэсэн протоколд ажлыг гэрээт хугацаандаа дууссанаар дүгнэсэн
6	ХУД, 19-р хорооллын NTU телевизийн арын уулзвар	"Пауэрложистикс" ХХК	1,021.7	2013.06.07	2013.07.08	Ростов ХХК	2013.07.08	-	Гэрээ дүгнэсэн протоколд ажлыг гэрээт хугацаандаа дууссанаар дүгнэсэн
7	Эрчим хүчний гудамж Ажилчны гудамжтай огтлолцох /урвалжингийн гүүрний урд талд/ замын уулзварын зам барилгын ажил гүйцэтгэх	"Цүүрдэн" ХХК	875.1	2013.07.22	2013.08.20	Танил санаа ХХК	2013.09.17	-	Гэрээ дүгнэсэн протоколд ажлыг гэрээт хугацаандаа дууссанаар дүгнэсэн
8	3, 4 дүгээр хорооллын эцсийн уулзварын зам барилгын ажил гүйцэтгэх	"Пабликроуд" ХХК	1,593.0	2013.08.06	2013.09.01	Ти Ай Би ХХК	2014.04.25	-	Гэрээ дүгнэсэн протоколд ажлыг гэрээт хугацаандаа дууссанаар дүгнэсэн
9	"Дулааны 3-р цахилгаан станц"-ын баруун хойд замаас урагшаа яармагийн гүүр хүртэлх 1,5 км зам барилгын ажил	"Эрдэнэ зам" ХХК	6,884.4	2013.08.15	2013.09.22	Ар Си Эс Си ХХК	2015.01.06	-	Гэрээ дүгнэсэн протоколд ажлыг гэрээт хугацаандаа дууссанаар дүгнэсэн

10	Ботаникаас Шархад чиглэлийн 6,6 км авто замын төгсгөлийн хэсэг буюу 2.36 км авто зам	"Билгэт зам"ХХК	3,883.4	2014.06.06	2014.09.01	ТЭТТ ХХК	2015.01.29	-	Гэрээ дүгнэсэн протоколд ажлыг гэрээт хугацаандаа дууссанаар дүгнэсэн
11	Хан уул дүүргийн арын уулзварын барилга угсралтын ажил	Алтанбалыш ХХК	1,844.8	2014.07.23	2014.10.01	Мөнхий тод зам ХХК	2014.11.14	-	Гэрээ дүгнэсэн протоколд ажлыг гэрээт хугацаандаа дууссанаар дүгнэсэн
12	Циркийн хойд уулзварын зам барилгын ажил гүйцэтгэх	"Ведледайна Монголиа" ХХК	849.5	2013.08.20	2013.10.10	Эм Си Пи Си жи ар ХХК	2013.12.11	-	Гэрээ дүгнэсэн протоколд ажлыг гэрээт хугацаандаа дууссанаар дүгнэсэн
13	Дарь эхийн уулзвар	"Экспресс зам" ХХК	1,398.7	2013.06.06	2013.07.08	Ар Си Эс Си ХХК	2013.08.27	2015.07.16	Гэрээ дүгнэсэн протоколд ажлыг гэрээт хугацаандаа дууссанаар дүгнэсэн
14	Гэмтлийн эмнэлгийн баруун урд уулзвар, Ард аюулийн өргөн чөлөө, Нэгдүгээр хорооллын арын зам барилгын ажил гүйцэтгэх	"Экспресс зам" ХХК	4,057.8	2013.08.08	2013.10.15	ХЗТ-Авто зам ХХК	2013.11.19	-	Гэрээ дүгнэсэн протоколд ажлыг гэрээт хугацаандаа дууссанаар дүгнэсэн
15	Цэцэг төвийн уулзвараас "Корпорейт" зочид буудлын замтай холбох 0.45 км авто замын ажил	"Экспресс зам" ХХК	2,249.5	2014.06.05	2014.07.10	Эйч Ай Би ХХК	2014.11.17	2014.11.18	Гэрээ дүгнэсэн протоколд ажлыг гэрээт хугацаандаа дууссанаар дүгнэсэн
16	Баянгол дүүргийн 3,4 дүгээр хорооллын эхлэл Энэбишийн өргөн чөлөө, Ахуй үйлчилгээний зүүн урд уулзварын өргөтгөл шинэчлэлтийн авто зам	"Наранбулаг Хан" ХХК	6,119.6	2014.07.04	2014.08.25	Дөрвөн тэнхлэг	2014.12.31	2015.02.11	Гэрээ дүгнэсэн протоколд ажлыг гэрээт хугацаандаа дууссанаар дүгнэсэн
17	ХУД, "Атар өргөө" ХХК-ийн урд замаас "Дулааны 3-р цахилгаан станц"-ын урд уулзвар хүртэлх 1,2 км авто замын зам барилгын ажил	"Наранбулаг хан" ХХК	4,204.1	2013.08.23	2013.11.10	Мондаэ ХХК	2014.01.23	-	Гэрээ дүгнэсэн протоколд ажлыг гэрээт хугацаандаа дууссанаар дүгнэсэн
18	"Дулааны 3-р цахилгаан станц"-ын урд уулзвараас Дарьгагийн гүүр хүртэлх 1.0 км авто замын зам барилгын ажил	"Мон роуд" ХХК	1,895.6	2013.08.23	2013.10.15	Мондаэ ХХК	2014.01.23	-	Гэрээ дүгнэсэн протоколд ажлыг гэрээт хугацаандаа дууссанаар дүгнэсэн
	Нийт		43,526.5						

Гэрээний хугацааг бодитой тооцоогүй зөрчлийн судалгаа

Хавсралт №3

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний хэрэгжилт						Алданги			Тайлбар
		Гэрээ байгуулсан огноо	Гэрээний дүн /сая.төг/	эхлэх	ажил гүйцэтгэх хугацаа	дуусах	Дууссан буюу ажил дуусах мэдэгдэл ирүүлсэн огноо	Хугацаа хоцорсон хоног	Гэрээнд заасны дагуу гэрээний нийт үнийн дүнгийн 0.5 хувиар тооцоход /сая.төг/	Гэрээнд заасны дагуу нийт алдангийн хэмжээ үнийн дүнгийн 10 хувь байхаар тооцоход /сая.төг/	
1	Саппорогийн аюулгүйн тойргийн өргөтгөл шинэчлэлт	огноогүй	2,433.2	2013/06/03	2013/05/31	2013/06/20	2013/09/18	90	1,094.9	243.3	
2	Бөхийн өргөөний арын уулзварын зам барилгын ажил	2013.08.09	985.9	2013/07/22	2013/07/19	2013/08/20	2013/09/30	41	202.1	98.6	
3	Өргөө кино театрын урд уулзвар	огноогүй	1,590.5	2013/05/27	2013/05/24	2013/06/10	2013/09/23	105	835.0	159.1	
4	100 айлын уулзварын барилга угсралтын ажил	2014.06.02	1,209.3	2014/05/30	2014/05/20	2014/06/30	2014/07/29	29	175.3	120.9	
5	10-р хорооллын уулзвар	огноогүй	1,247.9	2013/07/08	2013/07/08	2013/08/20	2013/12/04	106	661.4	124.8	
6	Хан уул дүүргийн арын уулзварын барилга угсралтын ажил	2014.09.16 2014.07.23	1,844.9	2014/07/23	2014/07/23	2014/10/01	2014/11/18	48	442.8	184.5	
7	Циркийн хойд уулзварын зам барилгын ажил гүйцэтгэх	2013.09.20 2013.08.20	849.6	2013/08/20	2013/08/20	2013/10/10	2013/12/09	60	254.9	85.0	Захиалагч болон бусад хүчин зүйлсийн нөлөөллөөс хугацаа алдсан гэж үзэн ямар нэг хариуцлага тооцоогүй
8	Ботаникаас Шархад чиглэлийн 6,6 км авто замын төгсгөлийн хэсэг буюу 2,36 км авто зам	2014.06.20 2014.06.06	3,883.4	2014/06/06	2014/06/06	2014/09/01	2014/10/22	51	990.3	388.3	
9	Цэцэг төвийн уулзвараас "Корпорейт" зочид буудлын замтай холбох 0,45 км авто замын ажил	2014.06.05 2015.07.06	2,249.5	2014/06/05	2014/06/05	2014/07/10	2014/09/12	64	719.9	225.0	
10	Баянгол дүүргийн 3,4 дүгээр хорооллын эхлэл Энэбишийн өргөн чөлөө, Ахуй үйлчилгээний зүүн урд уулзварын өргөтгөл шинэчлэлтийн авто зам	2014.07.04 2015.07.06	6,119.6	2014/07/04	2014/07/04	2014/08/25	2014/09/15	21	642.6	612.0	
11	"Дулааны 3-р цахилгаан станц"-ын урд уулзвар хүртэлх 1,2 км авто замын зам барилгын ажил	2013.09.20 2013.08.23	4,204.1	2013/08/23	2013/08/23	2013/11/10	2013/11/29	19	399.4	399.4	
12	Тээврийн дээд сургууль /хуучнаар Төмөр замын дээд сургууль/	2013.08.08	391.7	2013/06/10	2013/06/10	2013/07/01	2013/12/10	162	317.3	39.2	Гүйцэтгэжээс шалтгаалсан хугацаа алдалт 6 хоног гэж дүгнээд 11.8 сая төгрөгийн алданги тооцсон
	НИЙТ		26,618.06						6,418.55	2,640.79	

Гэрээ байгуулахаас өмнө ажил эхлүүлсэн зөрчлийн судалгаа

Хавсралт №4

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн /сая.төг/	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээ байгуулсан огноо	Ажил эхлэх	Ажил эхэлсэн	Ажил дуусах
1	Бөхийн өргөөний арын уулзварын зам барилгын ажил	985.9	"Төгс үржих зам" ХХК	2013/08/09	2013/07/22	2013/07/19	2013/08/20
2	Тээврийн дээд сургууль /хуучнаар Төмөр замын дээд сургууль/	391.7	"Дагшин харгуй" ХХК	2013/08/08	2013/06/10	2013/06/10	2013/07/01
3	100 айлын уулзварын барилга угсралтын ажил	1,209.3	"Пабликроуд" ХХК	2014/06/02	2014/05/30	2014/05/30	2014/06/30
4	ХУД, 19-р хорооллын NTV телевизийн арын уулзвар	1,021.7	"Пауэрложистикс" ХХК	2013/07/04	2013/06/07	2013/06/07	2013/07/08
5	Эрчим хүчний гудамж Ажилчны гудамжтай огтлолцох /гурвалжингийн гүүрний урд талд/ замын уулзварын зам барилгын ажил гүйцэтгэх	875.1	"Цүүрдэн" ХХК	2013/08/09	2013/07/22	2013/07/22	2013/08/15
6	Хан уул дүүргийн арын уулзварын барилга угсралтын ажил	1,844.9	Пауэр Пожистик ХХК	2014/09/16	2014/07/23	2014/07/23	2014/10/01
7	Циркийн хойд уулзварын зам барилгын ажил гүйцэтгэх	849.5	"Велдедлайне Монголиа" ХХК	2013/09/20	2013/08/20	2013/08/18	2013/10/10
8	ХУД, "Атар өргөө" ХХК-ийн урд замаас "Дулааны 3-р цахилгаан станц"-ын урд уулзвар хүртэлх 1,2 км авто замын зам барилгын ажил	4,204.1	"Наранбулаг хан" ХХК	2013/09/20	2013/08/23	2013/08/23	2013/11/10
9	"Дулааны 3-р цахилгаан станц"-ын урд уулзвараас Яармагийн гүүр хүртэлх 1,0 км авто замын зам барилгын ажил	1,895.6	"Мон роуд" ХХК	2013/09/20	2013/08/23	2013/08/24	2013/10/15
10	Дарь эхийн уулзвар	1,398.7	"Экспресс зам" ХХК	2013/07/05	2013/06/06	2013/06/05	2013/07/08
	Нийт	14,676.4					

Барьцаа хөрөнгө дутуу суутгасан зөрчлийн судалгаа

Хавсралт №5

код	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээний үнийн дүн /сая.төг/	Гэрээгээр барьцаа хөрөнгө суутгах /сая.төг/	Гүйцэтгэлээр барьцаа хөрөнгө суутгасан /сая.төг/	Дутуу суутгасан барьцаа хөрөнгө /сая.төг/
1	Бөхийн өргөөний арын уулзварын зам барилгын ажил	"Төгс үржих зам" ХХК	985.9	49.3	44.3	5.0
2	Тээврийн дээд сургууль /хуучнаар Төмөр замын дээд сургууль/	"Дагшин харгуй" ХХК	391.7	19.6	15.7	3.8
3	ХУД, 19-р хорооллын NTV телевизийн арын уулзвар	"Пауэрложистикс" ХХК	1,021.7	51.1	49.5	1.6
4	10-р хорооллын уулзвар	"Скай стар" ХХК	1,247.9	62.4	59.9	2.5
5	Эрчим хүчний гудамж Ажилчны гудамжтай огтлолцох /гурвалжингийн гүүрний урд талд/ замын уулзварын зам барилгын ажил гүйцэтгэх	"Цүүрдэн" ХХК	875.1	43.8	43.5	0.3
6	Циркийн хойд уулзварын зам барилгын ажил гүйцэтгэх	"Велдедлайне Монголиа" ХХК	849.5	42.5	40.8	1.6
7	3, 4 дүгээр хорооллын эцсийн уулзварын зам барилгын ажил гүйцэтгэх	"Паблицроуд" ХХК	1,593.0	79.7	67.8	11.8
8	"Дулааны 3-р цахилгаан станц"-ын баруун хойд замаас урагшаа яармагийн гүүр хүртэлх 1,5 км зам барилгын ажил	"Эрдэнэ зам" ХХК	6,884.4	344.2	312.2	32.0
9	Ботаникаас Шархад чиглэлийн 6,6 км авто замын төгсгөлийн хэсэг буюу 2,36 км авто зам	"Билэгт зам" ХХК	3,883.4	194.2	187.6	6.6
10	Хан уул дүүргийн арын уулзварын барилга угсралтын ажил	Алтанбалыш ХХК	1,844.8	92.2	78.5	13.8
11	Гэмтлийн эмнэлгийн баруун урд уулзвар, Ард аюушийн өргөн чөлөө, нэгдүгээр хорооллын арын зам барилгын ажил гүйцэтгэх	"Экспресс зам" ХХК	4,057.78	202.89	198.06	4.8
12	Цэцэг төвийн уулзвараас "Корпорейт" зочид буудлын замтай холбох 0.45 км авто замын ажил	"Экспресс зам" ХХК	2,249.53	112.48	110.50	2.0
13	Баянгол дүүргийн 3,4 дүгээр хорооллын эхлэл Энэбишийн өргөн чөлөө, Ахуй үйлчилгээний зүүн урд уулзварын өргөтгөл шинэчлэлтийн авто зам	"Наранбулаг Хан" ХХК	6,119.63	305.98	271.67	34.3
	Нийт		32,004.32	1,600.22	1,480.08	120.14

Барьцаа хөрөнгө хугацаанаас нь өмнө чөлөөлсөн зөрчлийн судалгаа

Хавсралт №6

Д/д	Ажлын нэр	Гүйцэтгэгч компани	Гэрээний дүн /сая.төг/	Ашиглалтад оруулсан огноо	Барьцаа хөрөнгө чөлөөлөх огноо	Барьцаа чөлөөлсөн		Түрүүлж чөлөөлсөн хоног
						Огноо	Дүн /сая.төг/	
1	Эрчим хүчний гудамж Ажилчны гудамжтай огтлолцох гурвалжингийн гүүрний урд талд замын уулзварын зам барилгын ажил гүйцэтгэх	Цүүрдэн ХХК	875.1	2013/12/05	2016/12/05	2016/05/16	43.5	203
2	Өргөө кино театрын урд уулзвар	Пабликроуд ХХК	1,590.5	2013/10/10	2016/10/10	2016/05/16	79.5	147
3	3, 4 дүгээр хорооллын эцсийн уулзварын зам барилгын ажил	Пабликроуд ХХК	1,356.8	2013/12/26	2016/12/26	2016/05/16	67.8	224
4	100 айлын уулзварын барилга угсралтын ажил	Пабликроуд ХХК	1,209.3	2014/11/20	2017/11/20	2016/05/16	60.5	553
5	Хан уул дүүргийн арын уулзварын барилга угсралтын ажил	Пауэр Пожистик ХХК	1,844.9	2015/01/30	2018/01/30	2016/06/03	49.5	606
6	Циркийн хойд уулзварын зам барилгын ажил	Велделайне Монголиа ХХК	849.6	2014/12/09	2017/12/09	2016/06/03	40.8	554
7	Баянгол дүүргийн 3,4 дүгээр хорооллын эхлэл Энэбишийн өргөн чөлөө, Ахуй үйлчилгээний зүүн урд уулзварын өргөтгөл шинэчлэлтийн авто зам	Наранбулаг Хан ХХК	6,119.6	2014/12/26	2017/12/26	2016/11/18	271.7	403
8	Халдвартын баруун урд уулзварын зам барилгын ажил	Готик голд ХХК	1,074.5	2013/11/28	2016/11/28	2016/11/18	52.5	10
9	“Дулааны 3-р цахилгаан станц”-ын урд уулзвараас Яармагийн гүүр хүртэлх 1,0 км авто замын зам барилгын ажил	Монроуд ХХК	1,895.6	2015/01/09	2018/01/09	2016/11/18	94.8	417
10	10-р хорооллын уулзвар	Скай стар ХХК	1,247.9	2013/11/26	2016/11/26	2016/11/18	59.9	8
11	Тээврийн дээд сургуулийн урд уулзварын зам барилгын ажил /хуучнаар Төмөр замын дээд сургууль/	Дагшин харгуй ХХК	391.7	2013/12/03	2016/12/03	2016/11/18	15.7	15
12	Ботаникаас Шархад чиглэлийн 6,6 км авто замын төгсгөлийн хэсэг буюу 2,36 км авто зам	Билэгт зам ХХК	3,883.4	2014/11/25	2017/11/25	2016/06/03	187.6	540
	Нийт		22,338.9				1,023.8	

Ашиглалтад оруулах комиссын акт хугацаандаа баталгаажаагүй зөрчлийн судалгаа

Хавсралт №7

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний үнийн дүн /сая.төг/	Гэрээний хугацаа		Комиссын ажилласан хугацаа			
				Эхлэх	Дуусах	Ашиглалтад оруулах комисс ажилласан огноо	Комиссын акт баталгаажсан огноо	14 хоногт баталгаажсан эсэх	Дахин комисс ажилласан эсэх
1	Саппорогийн аюулгүйн тойргийн шинэчлэлт	"Наранбулаг Хан" ХХК	2,433.2	2013/06/03	2013/06/20	2013/10/14	2013/11/26	43	Үгүй
2	Бөхийн өргөөний арын уулзварын зам барилгын ажил	"Төгс үржих зам" ХХК	985.9	2013/07/22	2013/08/20	2013/10/14	2013/10/31	17	Үгүй
3	Өргөө кино театрын урд уулзвар	"Паблицроуд" ХХК	1,590.5	2013/05/27	2013/06/10	2013/08/07	2013/10/10	64	Үгүй
4	Тээврийн дээд сургууль /хуучнаар Төмөр замын дээд сургууль/	"Дагшин харгуй" ХХК	391.7	2013/06/10	2013/07/01	2013/10/07	2013/12/03	57	Үгүй
5	100 айлын уулзварын барилга угсралтын ажил	"Паблицроуд" ХХК	1,209.3	2014/05/30	2014/06/30	2014/09/02	2014/11/20	79	Үгүй
6	10-р хорооллын уулзвар	"Скай стар" ХХК	1,247.9	2013/07/08	2013/08/20	2013/09/19	2013/11/26	68	Үгүй
7	ХУД, 19-р хорооллын NTV телевизийн арын уулзвар	"Пауэрложистикс" ХХК	1,021.7	2013/06/07	2013/07/08	2013/08/07	2013/11/26	111	Үгүй
8	Эрчим хүчний гудамж Ажилчны гудамжтай огтлолцох /гурвалжингийн гүүрний урд талд/ замын уулзварын зам барилгын ажил гүйцэтгэх	"Цүүрдэн" ХХК	875.1	2013/07/22	2013/08/20	2013/09/12	2013/12/05	84	Үгүй
9	Циркийн хойд уулзварын зам барилгын ажил гүйцэтгэх	"Велдедлайне Монголиа" ХХК	849.5	2013/08/20	2013/10/10	2014/01/6	2014/02/13	38	Үгүй
10	3, 4 дүгээр хорооллын эцсийн уулзварын зам барилгын ажил гүйцэтгэх	"Паблицроуд" ХХК	1,593.0	2013/08/08	2013/09/01	2013/10/08	2013/12/26	79	Үгүй
11	"Дулааны 3-р цахилгаан станц"-ын баруун хойд замаас урагшаа яармагийн гүүр хүртэлх 1,5 км зам барилгын ажил	"Эрдэнэ зам" ХХК	6,884.4	2013/08/15	2013/09/22	2016/10/27	2016/11/15	19	Үгүй
12	ХУД, "Дулааны 3-р цахилгаан станц"-ын урд 4 замын уулзвар	"Рок Пэйнт" ХХК	1,168.9	2013/08/15	2013/09/29	2013/12/18	2014/01/28	41	Үгүй
13	Хан уул дүүргийн арын уулзварын барилга угсралтын ажил	Алтанбалыш ХХК	1,844.8	2014/07/23	2014/10/01	2014/10/09	2015/01/30	113	Үгүй
14	Дарь эхийн уулзвар	"Экспресс зам" ХХК	1,398.7	2013/06/06	2013/07/08	2013/07/07	2013/09/24	79	Үгүй
15	ХУД, "Атар өргөө" ХХК-ийн урд замаас "Дулааны 3-р цахилгаан станц"-ын урд уулзвар хүртэлх 1,2 км авто замын зам барилгын ажил	"Наранбулаг Хан" ХХК	4,204.1	2013/08/23	2013/11/10	2014/08/12	2014/09/18	37	Үгүй
16	"Дулааны 3-р цахилгаан станц"-ын урд уулзвараас Яармагийн гүүр хүртэлх 1,0 км авто замын зам барилгын ажил	"Мон роуд" ХХК	1,895.6	2013/08/23	2013/10/15	2013/12/10	2015/01/09	395	Үгүй
17	Цэцэг төвийн уулзвараас "Корпорейт" зочид буудлын замтай холбох 0.45 км авто замын ажил	"Экспресс зам" ХХК	2,249.5	2014/06/05	2014/07/10	2014/10/27	2014/11/11	15	Үгүй
18	Баянгол дүүргийн 3,4 дүгээр хорооллын эхлэл Энэбишийн өргөн чөлөө, Ахуй үйлчилгээний зүүн урд уулзварын өргөтгөл шинэчлэлтийн авто зам	"Наранбулаг Хан" ХХК	6,119.6	2014/07/04	2014/08/25	2014/12/09	2014/12/26	17	Үгүй
Нийт			37,963.4						



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/193

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан Нийцлийн аудитын түр журмын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гудамж төслийн нийслэлд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хөрөнгийн зарцуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилт”-д хийсэн эрсдэлийн аудитын тайланг хавсралтаар баталсугай.


2. Аудитын тайланг Сангийн яам, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Хот төлөвлөлт ерөнхий төлөвлөгөөний газар, Нийслэлийн Өмчийн харилцааны газар, Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төсөлд тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын тайланд дурьдагдсан зөрчлүүдийг арилган, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн сайд, Нийслэлийн Хот төлөвлөлт ерөнхий төлөвлөгөөний газар /Э.Анар/, Нийслэлийн Өмчийн харилцааны газар /Ч.Однанан/, Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төсөл /Б.Батболд/-д нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор /Б.Алтанзул/-т даалгасугай.

5. Аудитын хүрээнд бий болсон баримт бичиг, нотлох баримтыг зохих журмын дагуу архивын нэгж болгон хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу Үндэсний аудитын газрын архивт 7 хоногийн дотор хүлээлгэн өгөхийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын аудитор /Ж.Энхтуяа/-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig_Khereg\Tushaal\2017\1026NAG3.Docx

071220